



МОНГОЛ УЛСЫН ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн нийцлийн аудитын тайлан



*Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө хууль,
журмын дагуу зарцуулагдахгүй байна*

Улаанбаатар хот
2016 он

Агуулга

Тайланг бэлтгэсэн:	Товчилсон үгийн жагсаалт	2
ҮАГ-ын Нийцлийн аудитын газар	Аудит хийх үндэслэл, зорилт, хамарсан хүрээ, арга зүй	3
	Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт	3
	Үндсэн мэдээлэл	4
	Бүлэг 1. ОНХС-ийн орлогыг хуульд заасан нэр төрөл бүрээр үндэслэлтэй төлөвлөж, хуваарилаагүй байна	
Газрын дарга Б.Алтанзул	1.1. Аймаг, нийслэл ОНХНС-аас олгох орлогын шилжүүлэг, бусад эх үүсвэрийг Төсвийн тухай хууль, Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын дагуу төлөвлөөгүй байна.....	5-6
Аудитын менежер З.Ариунзаяа	1.2. Зарим аймгууд сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хуваарилахдаа холбогдох журам, батлагдсан хуваарийг мөрдөөгүй байна	6-7
Ахлах аудитор Л.Хонгорзул	1.3. ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээ нь орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй, эрэмбэлсэн жагсаалтын дагуу төлөвлөгдөөгүй байна	7-9
Шинжээч Г.Ганбаатар А.Ариунзаяа М.Туул	1.4. ОНХС-ийн хөрөнгөөр зураг төсөвгүй, ТЭЗҮ-ийг тооцоогүй, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна	9-10
	Бүлэг 2. Орон нутгийн удирдлага ОНХНС-ийн орлогын шилжүүлгээс бусад эх үүсвэрийг хуульд заасан нэр төрлөөр бүрдүүлээгүй, орлого нэмэгдүүлэх талаар санаачлагагүй ажилласан байна	
2016 оны 6 дугаар сар	2.1. ОНХНС-аас аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 21.2 тэрбум төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн байна	11-12
Уг тайланг ҮАГ-ын Вэб сайтаас үзнэ үү. www.audit.mn	2.2. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан үнэлгээний хороо, ажлын хэсэг холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллаагүй байна	12-16
Аудитын тайлан дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 261729, 260949 дугаарын утас, факсаар харилцана уу.	2.3. ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг бүртгэл тайланд бүрэн тусгаагүй, төсөл, арга хэмжээг хүлээн авах комисс хангалтгүй ажилласан байна	17-21
	Бүлэг 3. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтэд тавих хяналт хангалтгүй байна	
	3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим төсөл арга, хэмжээний захиалагчийн хяналт хангалтгүй байгаа нь ажлын чанарт сөргөөр нөлөөлж байна	22-23
	3.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, хөрөнгийн зарцуулалтын мэдээллийг олон нийтэд мэдээлсэн байна	23
Хаяг:	3.3. Орон нутгийн удирдлагууд өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг арилгах талаар дорвитой арга хэмжээ авч ажиллахгүй байна	24
Үндэсний аудитын газар	3.4. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулаагүй байна.....	24-25
Чингэлтэй дүүрэг,	Холбогдох байгууллагын санал	26-27
Бага тойруу-3	Саналд өгөх тайлбар	27
Засгийн газрын IY байр	Дүгнэлт	28
Улаанбаатар хот 15160	Зөвлөмж	29
Монгол Улс	Монгол Улсын Ерөнхий аудиторовын тушаал	30
	Хавсралт.....	31

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААН	Аж ахуйн нэгж байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АМНАТ	Ашигт малтмалын нөөц ашигласны төлбөр
БГД	Баянгол дүүрэг
БНД	Багануур дүүрэг
БЗД	Баянзүрх дүүрэг
ГЕГ	Гаалийн ерөнхий газар
ИНХ	Иргэдийн нийтийн хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
ИШС	Инжинерийн шугам сүлжээ
ЗД	Засаг дарга
ЗДТГ	Засаг даргын тамгын газар
ЕБС	Ерөнхий боловсролын сургууль
НББТХ	Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
НИТХ	Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурал
НТХ	Нийтийн тээврийн хэрэгсэл
НТШ	Нээлттэй тендер шалгаруулалт
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНО	Олон нийтийн оролцоотой
ХААА	Худалдан авах ажиллагааны алба
ХАА	Худалдан авах ажиллагаа
ХААГ	Худалдан авах ажиллагааны газар
ХА	Харьцуулалтын арга
ХБИ	Хөгжлийн бэрхшээлтэй иргэн
ХХААЯ	Хүнс, хөдөө аж ахуйн яам
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХУД	Хан-Уул дүүрэг
ХТШ	Харьцуулсан тендер шалгаруулалт
ЦЭХ	Цахилгаан эрчим хүч
СБТХ	Стратеги бодлого төлөвлөлтийн хэлтэс
СӨХ	Сууц өмчлөгчдийн холбоо
СТСХ	Санхүү төрийн сангийн хэлтэс
СХД	Сонгинохайрхан дүүрэг
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕГ	Татварын ерөнхий газар
ТБОНӨХБАҮХАТХ	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үндэслэл
УУЯ	Уул уурхайн яам
УИХ	Улсын Их Хурал
ҮАГ	Үндэсний аудитын газар
ШГ	Шууд гэрээ
ШХА	Шууд худалдан авах
ЭМТ	Эрүүл мэндийн төв

Аудит хийх үндэслэл

Аудитыг Улсын Их Хурлын Төсвийн байнгын хорооны 2016 оны 01 дүгээр тогтоолыг үндэслэн Монгол Улсын Ерөнхий аудиторт ҮАГ-аас 2016 онд нийлүүлэх бүтээгдэхүүн, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1-д тодорхойлсон ҮАГ-ын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.

Аудитын зорилт

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн 2015 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт нь хууль, тогтоомжид нийцсэн эсэхэд аудит хийж, дүгнэлт, зөвлөмж боловсруулан дүнг УИХ, Засгийн газарт танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Энэ зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

- Орон нутгийн хөгжлийн сангийн орлогыг хуульд заасан нэр төрлөөр нь бодитой төлөвлөж, бүрдүүлсэн эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журмын дагуу зарцуулсан эсэх;
- Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг хууль журмын дагуу зохион байгуулж, олон нийтэд ил тод мэдээлсэн эсэх;
- Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Аудитын хамарсан хүрээ болон хугацаа

Аудитад ОНХНС, аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ, ЗДТГ, СТСХ, ХААГ, СБТХ, баг хороо, ОНХС-ийн хөрөнгийн 2015 оны төлөвлөлт, бүрдүүлэлт, хуваарилалт, зарцуулалт, санхүүжүүлсэн төсөл, арга хэмжээг хамруулав.

Аудитын арга зүй

Аудитыг гүйцэтгэхдээ АДБОУС 4100, Төрийн хяналт шалгалтын стандарт түүнийг хэрэгжүүлэх аргачилсан зөвлөмж, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийг мөрдлөг болгон холбогдох байгууллагуудын албан тушаалтнуудтай ярилцлага хийх, шаардлагатай нотлох баримт, судалгаа, тоон мэдээлэлд дүн шинжилгээ хийх, санхүүгийн тайлан, хөрөнгийн данс, анхан шатны баримт, төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, тайланг тулган баталгаажуулах зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын дүн, дүгнэлт, зөвлөмж боловсруулсан болно.

Аудитын дүн, дүгнэлтэд дэмжлэг болох нотлох зүйлс, холбогдох мэдээ, судалгааг ажлын баримт материалд хавсаргав.

Аудитад ашигласан хууль тогтоомж, шалгуур үзүүлэлт

Аудитад дараах хууль, эрх зүйн актууд болон аудитын стандартуудыг шалгуур үзүүлэлт болгон ашиглав. Үүнд:

- Төрийн аудитын тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- 2015 оны төсвийн тухай хууль болон хуульд орсон нэмэлт өөрчлөлт;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- ЗГ-ын 2012 оны 30 дугаар тогтоол;
- Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаал;
- Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаал;
- Сангийн сайдын 2014 оны 212 дугаар тушаал;
- ТБОНӨХБАҮХАТ хууль;
- Барилгын тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- АДБОУС 100-400, 4100;
- Дээрх хуулиудтай нийцүүлэн гаргасан дүрэм, журам, бусад эрх зүйн актууд.

Үндсэн мэдээлэл:

Монгол Улсын Төсвийн тухай хуульд *“Орон нутгийн хөгжлийн сан гэж орон нутгийн хөгжлийг дэмжих, бүс нутгийн тогтвортой байдлыг хангах зорилгоор улсын төсвөөс орон нутгийн төсөвт олгохоор дахин хуваарилалт хийх хөрөнгийг хэлнэ”* гэж заасан байна.

Монгол Улсын 2015 оны Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлд ОНХНС-аас ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 127.2 тэрбум төгрөгөөр баталсныг Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай 2015 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн хуулиар 126.8 тэрбум, мөн оны 10 дугаар сарын 30-ны өдрийн хуулиар 127.2 тэрбум төгрөг болгон тус тус өөрчилсөн байна.

Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас ОНХС-д олгох шилжүүлгийг тооцохдоо Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан *“Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал”*-ыг мөрдөж байна.

Орон нутгийн удирдлага улсын төсвөөс орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор хуваарилагдсан хөрөнгийг төлөвлөх, батлах, хуваарилах, нутгийн захиргаа, иргэд, олон нийтийн оролцоотой хамтын шийдвэрээр ил тод хариуцлагатай захиран зарцуулах, хяналт тавих, тайлагнах үйл ажиллагааг Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан *“Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”*, 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан *“Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”*-ыг баримтлан хэрэгжүүлж байна.

Аймаг, нийслэлийн ОНХС-д Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 2015 онд гүйцэтгэлээр 105.9 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгож, орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашгаас 8.2 тэрбум, татварын хувь хэмжээг нэмэгдүүлснээр 10.3 тэрбум, зарлагыг хэмнэх замаар болон орон нутгийн бусад орлогоор 4.6 тэрбум, хандив тусламжаар 3.7 тэрбум, нийт 132.8 тэрбум төгрөгийн орлогын эх үүсвэр төвлөрсөн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр аймаг, нийслэл, сум, дүүргүүдэд он дамжин үргэлжлэх 1435, шинэ онд хэрэгжүүлэх 3792, нийт 5227 төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэхээр баталснаас ОНХНС-аас олгосон орлогын шилжүүлгийн хэмжээ буурсан тул төлөвлөсөн ажлын 78.2 хувь буюу 4086 төсөл арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 9.5 хувь буюу 500 төсөл арга хэмжээ дутуу хэрэгжиж, 641 төсөл, арга хэмжээ огт хэрэгжээгүй байна.

ОНХНС-аас аймаг, нийслэлийн ОНХС-д олгосон орлогын шилжүүлгийн гүйцэтгэл нь батлагдсан дүнгээс 16.7 хувиар дутуу байна.

БҮЛЭГ 1. ОНХС-ийн орлогыг хуульд заасан нэр төрөл бүрээр төлөвлөж, хуваарилаагүй байна

1.1. Аймаг, нийслэл ОНХС-аас олгох орлогын шилжүүлэг, бусад эх үүсвэрийг Төсвийн тухай хууль, Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын дагуу төлөвлөөгүй байна

Сангийн яам 2015 оны ОНХС-ийн эх үүсвэрийг улсын хэмжээнд төлөвлөхдөө шаардлагатай тоо, мэдээллийг хуульд заасны дагуу тухайн асуудлыг хариуцсан яамд болон салбар агентлагаас авсан боловч аймаг, нийслэлээс ОНХС-ийн орлогын эх үүсвэрийн тооцооллыг авч төсвийн төсөлд тусгаагүй нь Төсвийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.19¹, 14 дүгээр зүйлийн 14.2.2², 14.2.4³, 22 дугаар зүйлийн 22.6.3⁴, 27-р зүйлийн 27.2.2⁵, 32 дугаар зүйлийн 32.2.6⁶, 33 дугаар зүйлийн 33.2.6⁷, 67 дугаар зүйлийн 67.2⁸ дахь заалтуудыг хангаж ажиллаагүй байна.

Сангийн сайдын 2014 оны 4-1/3872 албан бичгээр “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2015 оны төсвийн төсөл, 2016-2017 оны төсвийн төсөөлөл бэлтгэх удирдамж”-д ОНХС-аас орон нутагт олгох орлогын шилжүүлгийн хязгаарыг тооцон хүргүүлсэн боловч аймаг, нийслэл “2015 оны төсвийн төсөл”-ийг Сангийн яаманд хүргүүлэхдээ ОНХС-ийн эх үүсвэрийн талаар санал тусгаагүй, сум, дүүргийн ОНХС-д хуваарилах тооцоолол, төлөвлөлтийг хийгээгүй, сум, дүүрэгт төсвийн төсөл боловсруулах удирдамжийг Сангийн сайдын 244 дүгээр тушаалаар баталсан журмын 3.2⁹-т зааснаар хүргүүлээгүй нь ЗГ-ын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан аргачлал, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах” журмын 6.1¹⁰, 12.2.5.г¹¹, 12.2.5.д¹², 12.2.7¹³ -д заасныг биелүүлээгүй байна.

ОНХС-ийн төсвийн төслийг боловсруулахдаа нэр бүхий аймгууд ОНХС-аас хуваарилагдсан шилжүүлгийн орлогоос бусад эх үүсвэрийг төлөвлөөгүй нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.4, 27 дугаар зүйлийн 27.1.1¹⁴, Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор батлагдсан “Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан

¹ Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь төсвийн төлөвлөлт, ... мэдээллийн нэгдсэн тогтолцоог удирдах

² Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэрэгжүүлэх хөтөлбөрийн санхүүжилтийг бодитой тодорхойлох

³ Өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах

⁴ Төсвийн төлөвлөлт, бүртгэл, тайлагналыг төсвийн ангилалын төрөл тус бүрээр, тэдгээрийн дэлгэрэнгүй ангиллын дагуу бэлтгэх

⁵ Хөрөнгө оруулалтын хөтөлбөрт тусгагдах шинэ болон үргэлжлэн хэрэгжих төсөл, арга хэмжээг санхүүжүүлэх эх үүсвэрээр ангилан тусгах

⁶ хөрөнгө оруулалтын арга хэмжээний жагсаалт /нэр төрөл, санхүүжилтийн эх үүсвэрээр/;

⁷ хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, хэрэгжүүлэх хугацаа, төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн/;

⁸ Орон нутгийн төсвийн төслийн танилцуулгад энэ хуулийн 32.2.1-32.2.12, 32.2.19, 32.2.20-д зааснаас гадна дараах зүйлийг тусгана:

⁹ Аймаг, нийслэлийн Засаг дарга холбогдох төсвийн захирагчид энэ журмын 3.1-д заасан төсвийн удирдамжийг хүлээн авсанаас хойш ажлын 3 өдрийн дотор хүргүүлнэ.

¹⁰ Аймаг, нийслэлийн Засаг дарга ОНХС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлалыг ашиглан тухайн шатны ОНХС-ийн эх үүсвэрийг дараах байдлаар тооцож төлөвлөнө: 6.1.1 ОНХС-аас олгох орлогын шилжүүлэг 6.1.2 Аймаг, нийслэлийн үндсэн тэнцлийн ашгийн суурь зарлагатай тэнцэх хэсэг; 6.1.3 Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох эх үүсвэр; 6.1.4 Зарлагыг хэмнэх замаар бий болгох эх үүсвэр; 6.1.5 Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор авах дотоод гадаадын хандив, тусламж.

¹¹ Эрэмбэлсэн жагсаалтыг үндэслэн энэ журмын 3 дугаар хавсралтад заасан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төсөл тодорхойлох маягыг бэлтгэнэ

¹² нэгдсэн жагсаалтад орсон хөтөлбөр төсөл, арга хэмжээ бүр тодорхойлох маягтай байна.

¹³ Сум, дүүргийн Засаг дарга эрэмбэлэгдсэн, орон нутгийн дунд хугацааны хөгжлийн хөтөлбөртэй уялдсан, энэ журмын 6.3-т заасан шаардлагыг хангасан нэгдсэн жагсаалтыг гаргах

¹⁴ төсвийн зарчмыг мөрдлөг болгох;

болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлал"-ын 2.2.2¹⁵, 2.2.3¹⁶, 2.2.4¹⁷ дэх заалтуудтай нийцэхгүй байна. Тухайлбал:

- "Нийслэлийн 2014 оны төсвийн гүйцэтгэлийн тайлан"-д тусгагдсан тухайн жилийн орлогоос давсан 9,979.7 сая төгрөгөөс ОНХС-д хуваарилаагүй, орлогын бусад эх үүсвэрийг төлөвлөөгүй;

- Булган, Дархан-Уул, Дорнод, Завхан, Өвөрхангай, Өмнөговь, Төв, Сэлэнгэ аймгууд ОНХС-ийн орон нутгийн орлогын эх үүсвэрийг тооцож төлөвлөөгүй.

Мөн Хөвсгөл аймаг нийгмийн халамжийн сангийн 1,216.3 сая төгрөгийн хөрөнгийг ОНХС-ийн эх үүсвэр болгож төлөвлөсөн нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4.11¹⁸, Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.2 дахь заалтыг зөрчсөн байна.

Аймаг, нийслэлийн удирдлагууд ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлтийн тооцооллыг дээрх аргачлалын дагуу хийгээгүйгээс сум, дүүргүүдэд төсөл, арга хэмжээ хэрэгжүүлэх хөрөнгийн эх үүсвэр дутагдах, хасагдах, нөгөө талаас төлөвлөгдөөгүй ажлууд хийгдэхэд хүргэсэн байна. /Хавсралт №1/

1.2 Зарим аймгууд сумын ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хуваарилахдаа холбогдох журам, батлагдсан хуваарийг мөрдөөгүй байна

ОНХС-аас хуваарилсан орлогын шилжүүлгийг аймаг, нийслэлийн Засаг дарга сум, дүүргийн ОНХС-д хуваарилахдаа Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.2, 59.3 дахь заалт, ЗГ-ын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан "ОНХС болон ОНХС-аас олгох шилжүүлэг тооцох аргачлал"-ын 3.2¹⁹, 4.1²⁰ дэх заалтуудыг баримтлаагүй байна. Тухайлбал:

- Сэлэнгэ аймаг 196.9 сая, Баян-Өлгий 515.2 сая, Говьсүмбэр 250.1 сая, Дархан-Уул 472.9 сая, Ховд 488.4 сая, Өвөрхангай 40.7 сая, Дундговь 335.7 сая, Сүхбаатар 670.5 сая, Увс 276.2 сая, Дорноговь 322.7 сая, Говь-Алтай 172.4 сая, Дорнод аймаг 269.7 сая, Завхан 157.6 сая, Хэнтий 8.4 сая төгрөгийг аймгийн ОНХС-д тус тус илүү тооцож хуваарилсан.

Засгийн газрын 2014 оны 242 дугаар тогтоолоор "Сумын хөгжлийн индекс тооцох аргачлал"-ыг баталж, сумын хөгжлийн 2013 оны индексийг 2014 оны 4 дүгээр улиралд багтаан зарлаж, цаашид 2 жилд 1 удаа тооцож байхыг ЭЗХЯ-нд даалгасан ч тухайн яам татан буугдаж, чиг үүрэг нь Сангийн яаманд шилжсэн байхад индексийг өнөөдрийг хүртэл тооцож зарлаагүй нь "Монгол Улсын яамны эрх зүйн байдлын тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1²¹ дэх заалтыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Сангийн яам ЗГ-ын дээрх тогтоолоор өгөгдсөн үүргийг биелүүлээгүй нь аймаг, нийслэлийн удирдлага Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.3.1²² дэх заалтыг зөрчихөд хүргэж байна.

Нийслэлийн ОНХС-аас дүүргүүдийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг хуваарилахдаа ЗГ-ын 2012 оны 30 дугаар тогтоолыг баримтлахгүй, НИТХ-ын 2012 оны 79 дүгээр тогтоолоор баталсан "Нийслэл, дүүргийн хөгжлийн сангийн төсвөөр хэрэгжүүлэх төсөл хөтөлбөр, үйл ажиллагааг төлөвлөх, хуваарилах, зарцуулах, тайлагнах журам"-ын дагуу тооцсон байна.

¹⁵ Төсвийн тухай хуулийн 59.2-т заасан хөрөнгө

¹⁶ Төсвийн тухай хуулийн 56.2-т заасан орон нутгийн төсвийн үндсэн тэнцлийн ашиг

¹⁷ татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх болон зарлагыг хэмнэх замаар бий болгосон нэмэгдэл эх үүсвэр

¹⁸ "Нийгмийн халамжийн сан" нь Засгийн газрын тусгай сангийн нэг төрөл бөгөөд тухайн санг Нийгмийн халамжийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т заасан үйлчилгээ, үйл ажиллагаанаас бусад зориулалтаар зарцуулахыг хориглоно

¹⁹ Орлогын шилжүүлгийн хуваарилалтад нөлөөлөх байдлын харгалзах хувийн жин

²⁰ Орон нутгийн хөгжлийн индексээс хамааруулан олгох орлогын шилжүүлгийн дүнг тооцоход хөгжлийн индекс багатай орон нутгийн засаг захиргааны нэгжид илүү хөрөнгө хуваарилагддаг байх зарчим баримтална.

²¹ хууль тогтоомж, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын шийдвэр, үүрэг даалгаврыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, биелэлтийг хангуулах;

²² Орон нутгийн хөгжлийн индексийг үндэслэж тогтооно

ЗГ-ын 30 дугаар тогтоолын харгалзах хувийн жинг НИТХ-ын 79 дүгээр тогтоолын харгалзах хувийн жинтэй харьцуулбал: /хувиар/

Үзүүлэлт	ЗГ-ын 30 дугаар тогтоол	НИТХ-ын 2012 оны 79 дугаар тогтоол	Зөрүү
Орон нутгийн хөгжлийн индекс-харгалзах хувийн жин	25	0	-25
Хүн амын тоо-харгалзах хувийн жин;	25	50	+25
Хүн амын нягтрал, алслалт, нутаг дэвсгэрийн хэмжээ-харгалзах хувийн жин	25	25	0
Орон нутгийн татварын идэвх санаачилга-харгалзах хувийн жин	25	25	0

Дээрх үзүүлэлтээс харахад НИТХ-ын 79 дүгээр тогтоолд зөвхөн хүн амын тоог харгалзан тооцооллыг хийж байгаа нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.28-д заасан бүс нутгийн тэнцвэртэй байдлыг хангах зорилготой нийцэхгүй байна.

1.3 ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх төсөл, арга хэмжээ нь орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй, эрэмбэлсэн жагсаалтын дагуу төлөвлөгдөөгүй байна

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Монгол Улсын Үндэсний хөгжлийн цогц бодлого /2007-2015, 2016-2021/, аймаг, нийслэл, сум, дүүргийг хөгжүүлэх ерөнхий төлөвлөгөө, Засаг даргын хэрэгжүүлэх үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, тухайн орон нутгийн эдийн засаг, нийгмийн зорилт зэрэг бодлогын баримт бичгүүдтэй уялдуулсан байна.

Гэвч зарим аймаг, сумдад батлагдсан маягтаар олон нийтийн нээлттэй санал асуулгыг зохион байгуулаагүй, аймаг, сумын орон нутгийн хөгжлийн бодлого, тэргүүлэх чиглэлтэй уялдаагүй хөтөлбөр, төсөл арга хэмжээг баталж хэрэгжүүлсэн нь Сангийн Сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 3.5²³, 5.7²⁴ дахь заалттай нийцэхгүй байна. Тухайлбал:

- Дорноговь аймгийн Хөвсгөл, Улаанбадрах сумд Эм эргэлтийн сангийн барилгыг шинээр бариулахын тулд засварын ажил нэрээр 118.1 сая төгрөг;
- Дорнод аймгийн Булган сумын хяналтын камер, Иргэний танхимын тоног төхөөрөмж, Гурванзагал сумын эхчүүдийн амрах байрны засвар, Сэргэлэн сумын Агро паркийн хөшөөний өргөтгөл, сумын төвд чанга яригч суурилуулах, гудамжны тохижилт, Баяндун сумын Дэд станц, гэрэлтүүлэг, Музейн тохижилт, Морь барианы талбайн тохижилт, Матад сумын интернет сүлжээний өргөтгөл, Цахим хичээлийн сургалт, уурхайн хог хаягдал цэвэрлэх зэрэг төсөл арга хэмжээг;
- Хөвсгөл аймаг Улаан-Уул сум “бэлчээр хамгаалах ажилд урамшуулал олгох”, “эмч боловсон хүчнийг дэмжих” 2 төсөл, арга хэмжээнд нийт 10.0 сая, Тосонцэнгэл сум нийт 6.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 3 хөтөлбөр, төсөл арга хэмжээ.

Мөн аймаг, сумдын удирдлага ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс ирүүлсэн саналыг нэгтгэж ИНХ-д хэлэлцүүлэх урьдчилсан жагсаалтыг бэлтгэсэн боловч жагсаалтад Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 12.2.2²⁵-т заасан зарим үзүүлэлтүүдийг тооцож тусгаагүй, баг, хорооны ИНХ-аар хэлэлцүүлж байгаа боловч хуралд оролцогчдийн ирцийг гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулаагүй, нэгдсэн жагсаалтыг хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл арга

²³ “ЗДТГ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл арга хэмжээг тухайн шатны ИТХ-д хэлэлцүүлэн батлуулахаар хүргүүлэхдээ тухайн орон нутгийн хөгжлийн хөтөлбөр төлөвлөгөөтэй хэрхэн уялдсан талаарх дэлгэрэнгүй тайлбар үндэслэл иргэдийн хурлын санал тэдгээрийг тусгасан байдал гэсэн дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргана”

²⁴ Баг хорооны Засаг дарга ИНХ-д иргэдийн саналын урьдчилсан жагсаалт, харьяа сум, дүүргийн ЗД-аас ирүүлсэн хөгжлийн бодлоготой уялдуулсан төслийн санал болон хурлын явцад иргэдээс гарсан саналыг нэг бүрчлэн хэлэлцүүлнэ

²⁵ “Хөтөлбөр төсөл арга хэмжээг хэрэгжүүлснээс бий болох үр өгөөжийг хэн хүртэх, хэдэн хүн ашиг хүртэх, иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлөх, төслийн нийт өртөг”

хэмжээ тус бүрээр хэлэлцэн батлаагүй, иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй төсөл, арга хэмжээг ИТХ-аар баталсан зэрэг нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.4²⁶, 60.3.6²⁷, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 5.11²⁸, 6.3.5²⁹, 6.7³⁰, 8.7³¹, 12.1.1³², 12.2.1.6³³, в³⁴, 12.2.2 а³⁵, б³⁶, в³⁷, г³⁸ дэх заалтуудыг тус тус зөрчсөн байна. Тухайлбал:

- Нийслэлийн бүх дүүргийн хорооны ИНХ-ын тэмдэглэлд батлагдсан маягтын дагуу хуралд оролцогчдийн ирцийг баталгаажуулаагүй, БЗД, БГД, ХУД-үүд иргэдээс санал асуулга авахдаа журамд заасан хугацааг баримтлаагүй, БНД иргэдээс авсан саналыг ИНХ-аар баталгаажуулаагүй;
- Архангай аймагт ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх 15 төсөл арга хэмжээг төлөвлөхдөө нийт 156 хүний бүрэлдэхүүнтэй нээлттэй хэлэлцүүлэг хийсэн баримттай боловч хэлэлцүүлгийн дүн хэрхэн гарсан, байгууллага, ААН, баг хороодоос ирүүлсэн саналыг нэгтгэж, жагсаалт гаргасан талаар нотлох баримтгүй, Чулуут сумын ИТХ иргэдийн саналд тусгаадаагүй ахлах сургуульд тоног төхөөрөмж бэлтгэх ажилд 7.0 сая, малжуулах ажилд 8.0 сая төгрөг баталж, санхүүжүүлсэн;
- Булган аймаг, аймгийн бүх сумд, Дорноговь аймгийн Мандах, Хөвсгөлөөс бусад сумд ОНХС-ийн эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний талаар иргэдээс ирүүлсэн саналыг нэгтгэж ИТХ-д хэлэлцүүлэх урьдчилсан жагсаалтыг бэлтгэсэн боловч уг жагсаалтад “Хөтөлбөр төсөл арга хэмжээг хэрэгжүүлснээс бий болох үр өгөөжийг хэн хүртэх, хэдэн хүн ашиг хүртэх, иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлөх, төслийн нийт өртөг”-ийг тусгаагүй;
- Говь-Алтай аймгийн ЗДТГ нь иргэдийн саналыг тэргүүлэх ач холбогдол, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусгаагүй, Алтай, Хөхморьт, Шарга, Эрдэнэ сумд нийт 77.3 сая төгрөгийн өртөгтэй 5 төсөл арга хэмжээг батлуулсан, Бугат сум 205.7 сая төгрөгийн 6 төсөл арга хэмжээг төлөвлөхдөө иргэдээс санал авсан эсэхийг нотлох баримтгүй, Алтай, Жаргалан, Төгрөг, Чандмань сумдын ИТХ 49.3 сая төгрөгийн өртөгтэй 13 хөтөлбөр, төсөл арга хэмжээг хурлаар шууд баталж, санхүүжүүлсэн;
- Орхон аймгийн сумдын ЗДТГ нь иргэдийн саналыг тэргүүлэх ач холбогдол, орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдуулан эрэмбэлж, төсвийн төсөлд тусгаагүй;
- Баян-Өлгий аймаг жагсаалтад ороогүй 39 төсөл, арга хэмжээнд 170.2 сая төгрөг баталсан, Баяннуур, Улаанхус, Бугат, Дэлүүн, Толбо, Буянт, Сагсай, Алтанцөгц зэрэг сумууд иргэдээс санал аваагүй 6 төсөл, арга хэмжээнд 33.0 сая төгрөг баталсан;
- Увс аймаг иргэдийн саналаар дэмжигдээгүй 4 төсөл, арга хэмжээнд 157.8 сая төгрөг баталсан;
- Сэлэнгэ аймаг 3 төсөл, арга хэмжээнд 24.0 сая, Баруунбүрэн, Ерөө, Орхон, Орхонтуул, Хушаат сумд иргэдийн саналыг эрэмбэлээгүй, багийн ИНХ-аас гарсан саналыг шууд ИТХ-аар батлуулсан, Алтанбулаг, Мандал сумд иргэдийн саналыг эрэмбэлж ИТХ-д хүргүүлсэн боловч хурлын тэмдэглэл болон холбогдох баримтгүй, Сант сумын Ивэн баг, Хушаат сумын багийн ИНХ-ын дарга нар ИНХ-аас гаргасан саналыг ИНХ-ын тогтоолоор баталгаажуулаагүй, Алтанбулаг, Хушаат сумд иргэдийн саналаар дэмжигдээгүй 2 төсөл, арга хэмжээнд 24.0 сая төгрөг баталсан;

²⁶ Нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа

²⁷ орон нутгийн иргэдийн саналыг аваагүй, орон нутгийн төсвийн төлөвлөгөөнд тусгаж батлаагүй зардал, арга хэмжээ

²⁸ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр тухайн онд төлөвлөж ажлын гүйцэтгэл баталгаажсан боловч санхүүжилт хийгдээгүй хөрөнгө оруулалт хөтөлбөр арга хэмжээг дараа жилийн төсөвт тусгаж батлуулна

²⁹ Иргэдийн оролцоог хангасан байх

³⁰ Аймаг, нийслэлийн ИТХ нь аймаг, нийслэлийн ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжих хөрөнгө оруулалт хөтөлбөр төсөл арга хэмжээний нэгдсэн саналыг төсөл тус бүрээр хэлэлцэн төсвийн төсөлд тусган Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журмын 3 дугаар хавсралтын дагуу батална.

³¹ ОНХС-ийн тухайн жилд зарцуулагдаагүй үлдэгдэл болон худалдан авах ажиллагааны үр дүнд бий болсон хэмнэлт нь ОНХС-ийн дансанд үлдэж, дараа жилийн санхүүгийн эх үүсвэртээ тусгагдан ИТХ-аар батлагдан хэрэгжих боломжтой

³² аймаг, нийслэлийн Засаг дарга тухайн шатны орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр тухайн жилд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөгөөний урьдчилсан жагсаалтыг боловсруулж, жил бүрийн 3 дугаар улиралд багтаан иргэд, олон нийтийн саналыг авна;

³³ Саналыг асуулгын хуудсаар авахад энэ журмын 1 дүгээр хавсралтад заасан маягтыг ашиглах ба маягтыг баг, хорооны айл өрх бүрт жил бүрийн 1 дүгээр улиралд багтаан хүргүүлнэ.

³⁴ Энэ журмын 12.2.1.а-д заасан хэлбэрээр санал асуулгыг явуулахдаа, жил бүрийн 2 дугаар улирлын эхний 30 өдөрт багтаан санал авна

³⁵ хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлснээс бий болох үр өгөөжийг хэн хүртэх;

³⁶ хэдэн хүн ашиг хүртэх;

³⁷ сум, дүүргийн иргэдийн амьдралд хэрхэн нөлөөлөх;

³⁸ төслийн нийт өртөг зэргийг тусгасан байна.

- Ховд аймаг, Мөнххайрхан, Ховд, Дуут сумд ИТХ-д 114.0 сая, чуулга уулзалт семинарт 214.0 сая төгрөгийг иргэдийн санал аваагүй баталсан;
- Баянхонгор аймаг иргэдийн саналаар дэмжигдээгүй 7 төсөл, арга хэмжээнд 67.9 сая, Увс аймгийн Давст, Сагил, Улаангом, Өмнөговь, Өлгий, Түргэн, Зүүнхангай зэрэг сумд иргэдийн санал аваагүй 12 төсөл, арга хэмжээнд 180.7 сая төгрөг баталж, санхүүжүүлсэн;
- Төв аймгийн Зуунмод хот нь 6 багтайгаас 2 багийн ИНХ-аас дэвшүүлсэн иргэдийн саналыг авч эрэмбэлж 5 төсөл, арга хэмжээнд 30.4 сая, Сэргэлэн сум ЗДТГ-т авто машинд 38.0 сая, микро автобус авахад 25.0 сая, Сүмбэр сумын соёлын өдрүүдийн арга хэмжээнд 6.5 сая, Өндөрширээт сум камержуулах ажилд 6.6 сая төгрөгийг иргэдийн санал авалгүй баталсан;
- Хөвсгөл аймгийн Засаг дарга ИТХ-аар иргэдийн саналаар дэмжигдээгүй, зорилго, хүрэх үр дүн, санхүүгийн тооцоо хийгдээгүй 6 төсөл, хөтөлбөрийг 306.8 сая төгрөгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөгөөнд тусгаж батлуулсан, Улаан-Уул сум 5.0 сая төгрөгийн өртөгтэй мэдээллийн төвийн техник хэрэгсэл;
- Дундговь аймаг Онцгой байдлын тоног төхөөрөмж бэлтгэх ажилд 10 суманд 54.4 сая, Цаг уурын хамгаалалтын торон хашааны засварт 10 суманд 10.8 сая, Өлзийт сум Иргэний танхимын үйл ажиллагааны зардалд 6.4 сая, Дэлгэрцогт, Говь-Угтаал сумд “Интернэт тавих” ажилд 9.0 сая, Сайнцагаан сум “Үндэсний бичиг үсгийн баяр”-ын зардалд 1.3 сая, “Төсөл хөтөлбөр арга хэмжээ” - ний зардалд аймгийн төв 50.0 сая, Өлзийт сум 13.9 сая, Дэлгэрхангай сум 2.1 сая, Сайнцагаан сум “Гэмт хэрэгээс урьдчилан сэргийлэх хөтөлбөр”-ийн зардалд 2.0 сая төгрөг зарцуулахаар баталсан;
- Завхан аймгийн 10 суманд онцгой байдал, цаг уурын тоног төхөөрөмж 65.2 сая, Дөрвөлжин, Нөмрөг, Завханмандал, Их-Уул, Эрдэнэхайрхан сумдад нийт 16 төсөл, арга хэмжээнд 62.4 сая төгрөгийг иргэдийн санал аваагүй баталсан;
- Дундговь аймгийн Өлзийт, Дэлгэрцогт, Говь-Угтаал, Сайнцагаан, Дэлгэрхаан сумдад нийт 7 төсөл, арга хэмжээнд 84.7 сая төгрөгийг иргэдийн санал аваагүй баталсан;
- Сүхбаатар аймгийн Дарьганга сум Соёлын төвийн цуурай дарах ажилд 2.2 сая, хүүхдийн цэцэрлэгийг хашаажуулахад 5.4 сая, Цагдаагийн машинд сэлбэг авахад 1.0 сая, Сүхбаатар сум өвсний фонд үүсгэхэд 10.4 сая, наадмын талбайн засварт 7.9 сая, Эрдэнэцагаан сум интернэтийн тоног төхөөрөмж суурилуулахад 24.0 сая нийт 59.5 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээг иргэдийн саналгүйгээр батлуулж, гүйцэтгэсэн;
- Говьсүмбэр аймгийн ОНХС-аас зөвхөн багцын нэрээр иргэдийн санал авч эрэмбэлсэн 10, иргэдийн санал авч эрэмбэлээгүй 4, нийт 14 хөтөлбөр, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр 467.4 сая, Сүмбэр, Шивээговь, Баянтал сумд төсвийн тодотгол хийхдээ иргэдийн санал авч, эрэмбэлэгдээгүй, багийн ИНХ-аар хэлэлцүүлээгүй 124.6 сая төгрөгийн 8 ажил, 7.1 сая төгрөгийн 3 хөтөлбөр, төсөл арга хэмжээг баталсан;
- Хэнтий аймгийн Баянхутаг, Өмнөдэлгэр, Бор-Өндөр, Батноров сумд “Архигүй Хэнтий”, “Эрүүл тохилог Өмнөдэлгэр”, “Золбин нохой устгал” зэрэг нийт 60.0 сая төгрөгийн 10 төсөл, арга хэмжээг иргэдийн санал авалгүй хэрэгжүүлсэн;
- Дорноговь аймгийн Сайншанд сум иргэдийн саналаар эрэмбэлэгдээгүй 4, 6 дугаар цэцэрлэгүүдийн дээврийн засвар, гадна дулаан, цэвэр усны шугамын иж бүрэн засвар, сургууль цэцэрлэгийг камержуулах, жишиг гудамж байгуулах 4 ажилд 197.5 сая, Улаанбадрах сум ЭМТ, Хүүхдийн цэцэрлэг, ЕБС, Нийтийн орон сууц зэрэг байгууллагын гадна засварт нийт 39.4 сая, Хөвсгөл сум Цаг уурын барилгын ажил, Соёл спортын цогцолбор барих ажлын зураг төсвийн ажилд нийт 76.3 сая төгрөг баталсан.

ОНХС-ийн хөрөнгөөр 2015 онд хэрэгжүүлэхээр батлагдсан нийт төсөл, арга хэмжээний 13.5 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй, 210 төсөл, арга хэмжээг иргэдийн саналаар дэмжигдээгүй байхад төлөвлөгөөнд тусгаж, ИТХ-аас баталж, хэрэгжүүлсэн нь “ОНХС-ийн заавар”-ын 4.2³⁹ дахь заалтын шаардлагыг биелүүлээгүй байна.

1.4 ОНХС-ийн хөрөнгөөр зураг төсөвгүй, ТЭЗҮ-ийг тооцоогүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан байна

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ нь ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг батлахдаа зураг төсөвгүй, ТЭЗҮ хийгдээгүй, газрын болон техникийн тодорхойлолтгүй, шаардагдах хөрөнгө, төсөвт өртгийг тооцоогүй

³⁹ Тухайн орон нутгийн иргэдийн саналыг авч зохих журмын дагуу эрэмбэлэгдсэн байх

төсөл, арга хэмжээг баталсан нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.2, 29 дүгээр зүйлийн 29.4⁴⁰, Сангийн сайдын 2014 оны 43 тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.7⁴¹, 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.3.3⁴², 12.2.5г⁴³ заалтуудтай нийцэхгүй байна. Тухайлбал:

- Говь-Алтай аймгийн хэмжээнд 36.2 сая төгрөгийн 8 хөтөлбөр, төсөл, арга хэмжээг зураг төсөө, ТЭЗҮ, техникийн тодорхойлолтогүй баталсан;
- Орхон аймгийн Согоот багийн гэрэлтүүлгийн ажил, Баянцагаан багийн орон сууцны инженерийн шугам сүлжээний засварын ажлууд зураг төсөөгүй;
- Хэнтий аймгийн Дэлгэрхаан суманд баригдсан 44.6 сая төгрөгийн өртөгтэй хүндэтгэлийн өргөө, Батширээт суманд 30.0 сая төгрөгийн өртөгтэй модон гүүр барих ажил, Баян-Адарга суманд 20.0 сая төгрөгийн өртөгтэй багийн хөгжлийн төв барих ажил, Бор-Өндөр суманд 17.4 сая төгрөгийн өртөгтэй тоглоомын талбай барих ажлууд зураг, төсөөгүй;
- Булган аймгийн Баян-Агт суманд Наадмын талбай шинэчлэх 19.8 сая төгрөгийн ажил, “Эрчим хүчний шугамыг шинэчлэн сайжруулах” 35.0 сая төгрөгийн ажил зураг төсөөгүй;
- Баян-Өлгий аймгийн Алтанцөгц сум 10.0 сая төгрөгийн Наадмын төв асар барих ажил, Булган сумын 30.0 сая төгрөгийн цахилгаан дамжуулах, агаарын шугам тавих ажил зураг төсөөгүй;
- Баянхонгор аймгийн Жинст, Баянлиг, Шинэжинст, Баацагаан, Эрдэнэцогт сум багийн төв барихад 230.4 сая, бусад 19 төсөл, арга хэмжээнд 328.1 сая төгрөгийг зураг, төсөөгүй баталсан, Богд, Баянговь, Баян-өндөр, Баацагаан, Эрдэнэцогт, Галуут сумд 5 ажлыг батлагдсаны дараа зураг төсвийг 57.7 сая төгрөгөөр хийлгэсэн;
- Сэлэнгэ аймгийн Орхонтуул сум 272.0 сая, Ерөө сум 105.0 сая, Жавхлант сум 30.0 сая, Сант сум 24.0 сая, Түшиг сум 32.4 сая, Цагааннуур сум 64.6 сая, нийт 527.9 сая төгрөгийн 6 төсөл, арга хэмжээ зураг төсөөгүй;
- Төв аймаг 3 ажлыг 496.0 сая төгрөгөөр гүйцэтгэхээр зураг төсөөгүй баталсан;
- Сүхбаатар аймагт барилга угсралтын ажил болон их засвар, тоног төхөөрөмж суурилуулах зэрэгт 1,354.4 сая төгрөгийн 35 ажил;
- Завхан аймгийн Шилүүстэй, Ургамал суманд сургуулийн тохижилт, халуун ус барих нийт 36 сая төгрөгийн 3 ажил;
- Дорноговь аймагт 202.7 сая төгрөгийн өртөгтэй 4 ажлын ТЭЗҮ, зураг төсөө нь батлагдаагүй;
- Хөвсгөл аймгийн Мөрөн, Рэнчинлхүмбэ сумдаас бусад сумдууд төсөл, арга хэмжээг ИТХ-аар баталсны дараа төсөвт нийцүүлэн техникийн нөхцөл нь боловсруулагдаж, зураг төсөө хийлгэсэн.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад зураг төсөө хийгдээгүй, иргэдийн саналыг аваагүй төсөл, арга хэмжээ оруулсан нь ОНХС-ийн хөрөнгийн үр өгөөжийг бууруулж, орон нутагт үр ашиггүй хөрөнгө нэмэгдэх нөхцлийг бүрдүүлсэн байна.

⁴⁰ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана

⁴¹ Хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ нь хуульд заасны дагуу ТЭЗҮ хийгдсэн, зураг төсөө нь батлагдсан, байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх

⁴² Хөрөнгө оруулалтын төсөл, хөтөлбөр, арга хэмжээ нь хуульд заасны дагуу техник эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсөө нь батлагдсан байгаль орчинд нөлөөлөх байдлын судалгаа хийгдсэн, бусад зөвшөөрөлтэй байх

⁴³ Эрэмбэлсэн жагсаалтыг үндэслэн энэ журмын 3 дугаар хавсралтад заасан хөтөлбөр, төсөл, арга хэмжээний төсөл тодорхойлох маягыг бэлтгэнэ

Бүлэг 2. Орон нутгийн удирдлага ОНХНС-ийн орлогын шилжүүлгээс бусад эх үүсвэрийг хуульд заасан нэр төрлөөр бүрдүүлээгүй, орлого нэмэгдүүлэх талаар санаачлагагүй ажилласан байна

2.1.ОНХНС-аас аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийг 21.2 тэрбум төгрөгөөр дутуу санхүүжүүлсэн байна

ОНХНС-ийн олгохоор тооцсон нийт 105.9 тэрбум төгрөгийн эх үүсвэрийн 70.4 хувь буюу 77.6 тэрбум төгрөгийг дотоодын НӨАТ, 18.2 хувь буюу 19.4 тэрбум төгрөгийг АМНАТ, 5.9 хувь буюу 6.3 тэрбум төгрөгийг аймаг, нийслэлээс төвлөрүүлсэн орлогын дахин хуваарилалт, 5.5 хувь буюу 5.9 тэрбум төгрөгийг газрын тосны НӨАТ-аас бүрдүүлсэн байна.

ОНХНС-аас аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлэг 21.2 тэрбум төгрөгөөр дутуу олгогдсон нь аймаг, нийслэлээс төвлөрүүлж дахин хуваарилах орлогын төлөвлөгөө 40 хувь, газрын тосны НӨАТ-ийн орлогын төлөвлөгөө 43 хувиар тасарсантай холбоотой байна.

Орлогын төлөвлөгөө гүйцэтгэлийг хүснэгтээр үзүүлбэл:

/сая.төг/

Д/Д	Эх үүсвэр:	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
1	Дотоод НӨАТ*25 хувь	72,783.00	82,456.50	113.3
2	АМНАТ*5 хувь	21,347.50	27,152.90	127.2
3	Аймаг нийслэлээс дахин хуваарилах	21,704.40	12,989.20	59.9
4	Газрын тосны НӨАТ*30хувь	11,324.00	6,415.60	56.6
	Нийт	127,159.00	129,014.10	

Монгол Улсын 2015 оны Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулиар ОНХНС-аас аймаг, нийслэлийн ОНХС-д олгох орлогын шилжүүлгийн хэмжээг 127.2 тэрбум төгрөгөөр баталж, гүйцэтгэлээр 83.3 хувь буюу 105.9 тэрбум төгрөгийн шилжүүлэг хийгдсэн байна.

ОНХС-д төвлөрүүлсэн эх үүсвэрийг хүснэгтээр үзүүлбэл:

/сая.төг/



Орон нутгийн орлого										
№	Аймгийн нэр	Өмнөх оны үлдэгдэл	ОНХНС-аас шилжүүлсэн санхүүжилт	Төсвийн үндсэн тэнцлийн ашгаас үлдэх хэсэг	Татварын хувь хэмжээг нэмэгдүүлсэн	Хандив	Бусад	Нийт	ОН-ийн орлогын эзлэх хувь	Нийт эх үүсвэр
1	Архангай	787.9	4,189.9		111.3		47.9	159.2	3.07	5,137.0
2	Баянхонгор	650.8	4,898.2			50	392.1	442.1	7.38	5,991.1
3	Баян-Өлгий	158.8	3,816.3				431.6	431.6	9.79	4,406.7
4	Булган	1,802.7	3,588.9			257.7		257.7	4.56	5,649.3
5	Говь-Алтай	1,285.8	4,732.1			134.9	44.9	179.8	2.88	6,197.7
6	Говьсүмбэр	86.9	2,721.1	887.6	200	9		1096.6	28.02	3,904.6
7	Дархан-Уул	192.4	3,535.5			5.9		5.9	0.16	3,733.8
8	Дорнод	144.9	4,282.9	204.9				204.9	4.42	4,632.7
9	Дорноговь	64.2	3,935.7	167.8				167.8	4.03	4,167.7
10	Дундговь	2,372.7	3,777.8	2,444.7		68.5	33.8	2547	29.28	8,697.5
11	Завхан	737.1	4,006.8	340	8.1	7.1		355.2	6.97	5,099.1
12	Орхон		3,812.3	978		583.8		1561.8	26.21	5,374.1
13	Өвөрхангай	398.7	4,615.8				10.0	10.0	0.2	5,024.5
14	Өмнөговь	1,403.1	4,674.9	2252	8,379.5	185.5		10817	64.02	16,895.0
15	Төв	916.2	3,817.1			0.7	778.7	779.4	14.14	5,512.7
16	Ховд	162.5	4,338.4			120.8	33.9	154.7	3.32	4,655.6
17	Хөвсгөл	15.3	4,573.2		135.5		1,233.70	1369.2	22.98	5,957.7
18	Хэнтий	31.7	4,094.8	647.1	25.7	73.7	130.1	876.6	16.6	5,003.1
19	Сүхбаатар	31.4	4,012.4	233.6	1,474.5	1,655.0	870.7	4233.8	51.15	8,277.6
20	Сэлэнгэ	346.2	3,709.6				2	2	0.05	4,057.8
21	Увс	240.8	3,890.9			559.0	576.6	1135.6	21.56	5,267.3
22	Улаанбаатар	4,619.3	20,960.0					0	0	25,579.3
	Нийт дүн	16,449.4	105,984.6	8,155.7	10,334.6	3,711.6	4,586.0	26,787.9		149,221.9

2015 онд зарим аймаг, нийслэлийн удирдлагууд “Төсвийн тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 14 дүгээр зүйлийн 14.2.2, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар баталсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6.1⁴⁴, 6.1.2⁴⁵, 6.1.3⁴⁶, 6.1.4⁴⁷, 6.1.5⁴⁸ дахь заалтын дагуу ОНХС-ийн хөрөнгийн бусад эх үүсвэрийг хууль, журамд заасан нэр төрлөөр нь бүрдүүлэх талаар санаачлагагүй ажилласан байна. Тухайлбал:

- Нийслэлийн ОНХС-д ОНХС-ийн шилжүүлгээс өөр эх үүсвэр төвлөрүүлээгүй, Архангай, Говь-Алтай, Дархан-Уул, Өвөрхангай, Ховд, Булган, Дорноговь, Сэлэнгэ аймгийн удирдлагууд Төсвийн тухай хуульд заасан бусад эх үүсвэрийг бүрдүүлэх талаар хангалтгүй ажилласан байна.

Аймаг, нийслэлийн ОНХС-ийн нийт эх үүсвэрийг бүтцээр нь авч үзвэл 11.0 хувь нь ОНХС-ийн өмнөх оны үлдэгдэл, 71.0 хувь нь ОНХС-ийн шилжүүлэг, 5.5 хувь нь үндсэн тэнцлийн ашиг, 6.9 хувь нь татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болгох эх үүсвэр, 2.5 хувь нь дотоод, гадаадын хандив тусламж, 3.1 хувь нь бусад эх үүсвэрээс бүрдсэн байна.

ОНХС-ийн орлогын төлөвлөгөө, гүйцэтгэлийн 3 жилийн харьцуулсан судалгааг графикаар харуулбал:



2.2. ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулсан үнэлгээний хороо, ажлын хэсэг холбогдох хууль, журмыг мөрдөж ажиллаагүй байна

ОНХС-ийн хөрөнгөөр 2015 онд шинээр хэрэгжүүлсэн нийт 3792 төсөл, арга хэмжээний 8.0 хувь буюу 303 ажлыг ТБОНӨХБАҮХАТХ-ийн дагуу нээлттэй тендер, 3.9

⁴⁴ Аймаг, нийслэлийн Засаг дарга орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан болон орон нутгийн хөгжлийн сангаас олгох шилжүүлэг тооцох аргачлалыг ашиглан тухайн шатны орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрийг дараахь байдлаар тооцож төлөвлөнө

⁴⁵ Аймаг, нийслэлийн үндсэн тэнцлийн ашгийн суурь зарлагатай тэнцэх хэсэг

⁴⁶ Татварын хувь хэмжээг нэмэгдүүлэх замаар бий болсон эх үүсвэр

⁴⁷ зарлагыг хэмнэх замаар бий болгох эх үүсвэр;

⁴⁸ Тухайн орон нутгийн хөгжлийг дэмжих зорилгоор авах дотоод, гадаадын хандив, тусламж

хувь буюу 146 ажлыг олон нийтийн оролцоотой болон хязгаарлагдмал тендер, 25.4 хувь буюу 963 ажлыг харьцуулалтын аргаар, 51.4 хувь буюу 1949 ажлыг шууд гэрээ байгуулах аргаар хэрэгжүүлж, 11.4 хувь буюу 431 ажилд ХАА зохион байгуулаагүй байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн ажлын сонгон шалгаруулалтыг хүснэгтээр харуулбал:

№	Аймгийн нэр	Төлөвлөсөн ажил		Худалдан авах ажиллагааны журам /тоогоор/				
		Өмнөх оноос шилжсэн	Шинэ оны ажил	НТШ	ХТШ, ОНОХА	ХА	ШГБ	ХАА зохион байгуулаагүй
1	Архангай	66	149	9	-	39	58	43
2	Баян-Өлгий	180	119	8	0	13	98	-
3	Баянхонгор	107	260	5	-	34	184	37
4	Булган	13	213	14		68	103	28
5	Говь-Алтай	51	229	27	26	27	121	28
6	Говьсүмбэр	50	82	8	1	9	53	11
7	Дархан-Уул	76	27	8	-	6	13	-
8	Дорноговь	-	62	7	6	25	18	6
9	Дорнод	-	110	10	3	29	68	-
10	Дундговь	49	161	15	20	43	83	-
11	Завхан	18	327	31	2	19	227	48
12	Орхон	36	65	4	-	35	26	-
13	Өвөрхангай	121	157	10	0	60	87	-
14	Өмнөговь	65	152	38	1	31	56	26
15	Төв	48	233	3	0	65	142	23
16	Ховд	99	226	20	2	61	143	-
17	Хөвсгөл	35	185	10	-	64	111	-
18	Хэнтий	73	263	11	-	37	177	38
19	Сүхбаатар	86	111	10	-	14	87	
20	Сэлэнгэ	102	115	7	0	52	27	29
21	Увс	83	192	5	0	107	27	53
22	Улаанбаатар	77	354	43	85	125	40	61
	Нийт дүн	1435	3792	303	146	963	1949	431

Аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг даргын захирамжаар томилогдсон үнэлгээний хороо, ажлын хэсгүүд ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, хөтөлбөрийн гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийн 7 дугаар зүйлийн 7.2⁴⁹, 7.1.2⁵⁰, 8 дугаар зүйлийн 8.4⁵¹, 8.5⁵², 39 дүгээр зүйлийн 39.12⁵³, 47 дугаар зүйлийн 47.4⁵⁴, 49 дүгээр зүйлийн 49.1⁵⁵ дэх заалтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна. Тухайлбал:

- Булган аймгийн 1 дүгээр сургуулийн барилгын засварын ажил 28.0 сая, худалдааны төвийн 49.9 сая, Сэлэнгэ сумын ЗДТГ-ын барилгын засварын зураг төсвийн 12.7 сая төгрөгийн ажлыг ШГ байгуулсан, Хишиг-эндөр сумын Очир баатарын хүндэтгэлийн талбайн ажлын төсөвт өртөгийг 2 хуваан НТШ-аас зайлсхийж, ХА-аар зохион байгуулсан, Баян-Агт суманд 14.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй "Багуудын тохижилт үйлчилгээ" төслийн гүйцэтгэгчтэй гэрээ байгуулаагүй;
- Архангай аймагт үнэлгээний хорооны зарим гишүүд оролцоогүй байхад ХАА-г зохион байгуулсан, үнэлгээний хорооны иргэний төлөөлөлд ХААА-ны гэрээт ажилтанг оруулсан, Цэнхэр

⁴⁹ хуулийн 7.1.2-7.1.4-т заасан журмыг хэрэглэхээр зааснаас бусад тохиолдолд нээлттэй тендер шалгаруулалтын журмыг мөрдөнө

⁵⁰ Сум, дүүргийн төсвийн хүрээнд худалдан авах хорин сая хүртэлх төгрөгийн өртөгтэй бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг олон нийтийн оролцоотойгоор зохион байгуулж болно

⁵¹ Тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо тухайн бараа, ажил, үйлчилгээний нийт төсөвт өртгийг үндэслэл болгоно

⁵² Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно

⁵³ Аудит, инженерийн ердийн тооцоо, зураг төсөл зэрэг хэвшсэн үйл ажиллагаатай, гэрээний төсөвт өртөг нь энэ хуулийн 8.1.3-т заасан босго үнээс хэтрээгүй зөвлөх үйлчилгээнд хосолмол үнэлгээний аргын хялбаршуулсан хэлбэр болох бага үнийн аргыг хэрэглэж болно

⁵⁴ "Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын 2-оос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажлын гүйцэтгэл хариуцлагатай" гэж үзсэн

⁵⁵ Захиалагч худалдан авах ажиллагаа явуулсан тухай бүр тендер шалгаруулалтын хавтаст хэрэг бүрдүүлж архивын нэгж болгон хадгална

сум 130.0 сая төгрөгийн төсөвт өртөг бүхий 7 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр байгуулсан гэрээнд ажил эхлэх, дуусах хугацаа, захиалагч гүйцэтгэгчийн хүлээх үүрэг хариуцлагыг тусгаагүй, гэрээний тусгай нөхцөлгүй, Хангай сум 110.3 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 6 ажлын гэрээ нь хуулийн шаардлага хангаагүй;

- Орхон аймгийн Баянцагаан багийн гэр хорооллыг инженерийн шугам сүлжээнд холбох 996.3 сая төгрөгийн ажлыг Жи Би Си Зэт ХХК-тай “Төлөвлөх-Зураг төсөл боловсруулах-Барих-Шилжүүлэх” нөхцөлтэй концессийн гэрээ хийсэн байхад 2015 онд ОНХС-ийн хөрөнгөөс 929.6 сая төгрөг олгосон, ажлын баталгаа болох 66.6 сая төгрөгийг 2016 онд ОНХС-н хөрөнгөөс санхүүжүүлэхээр төлөвлөж, баталсан;

- Говь-Алтай аймгийн Бигэр, Бугат, Цогт, Чандмань сумууд төсөвт өртөг нь 20 саяаас дээш төгрөгийн өртөгтэй 11 төсөл арга хэмжээг ОНО-той худалдан авах ажиллагааг сонгосон;

- Говьсүмбэр аймаг 25.0 сая төгрөгийн ном худалдан авах ажлыг жижиглэн ШХА аргаар гүйцэтгэсэн;

- Дархан-Уул аймгийн Дархан сумын “Жишиг хороолол-3” төслийн хүрээнд тоглоомын талбай, гэрэлтүүлгийн ажил, 9 дүгээр багт авто зогсоол, замын өргөтгөлийн ажил, 31 дүгээр хорооллын цэвэр усны ариутгал, татуурга, цахилгаан хангамжийн ажил, 6, 7, 15 дугаар багуудад хүүхдийн тоглоомын талбай байгуулах ажлуудын Үнэлгээний хорооны хурлын тэмдэглэл, дүгнэлтэд гарын үсэг дутуу зурагдсан;

- Хэнтий аймгийн Бор-Өндөр суманд хийгдсэн 32.0 сая төгрөгийн өртөгтэй “Усан оргилуур, тоглоомын талбай”-г тусгай зөвшөөрөлгүй иргэнээр гүйцэтгүүлсэн;

- Баян-Өлгий аймгийн Улаанхус сум нь он дамжсан хадлан хашиж хамгаалах, ойжуулалт, авто зам засах төсөл арга хэмжээнүүдэд гэрээний үнийн дүнгээс 2.1 сая төгрөг илүү олгосон;

- Сэлэнгэ аймгийн Мандал, Ерөө сумын гудамжны гэрэлтүүлгийн ажилд 14.1 сая, Хушаат сумын хүлэмжийн аж ахуй байгуулахад 1.0 сая, аймгийн төвийн замын зураг төсөв хийлгэх ажилд 2.0 сая, цэцэрлэгийн барилгын өргөтгөлийн зураг, төсвийн ажилд 1.7 сая төгрөг тус тус илүү олгосон;

- Ховд аймгийн Хүүхдийн паркийн тохижилтын ажлын 80 хувь болох 56.0 сая төгрөгийг 2015 оны 5 сард урьдчилж олгосон боловч одоо хүртэл ажил хийгдээгүй, 2016 онд гэрээг дахин сунгасан, сургуулийн спортын талбай байгуулах 116.2 сая төгрөгийн ажлын санхүүжилтийн 80 хувийг олгосон ч ажил дуусаагүй, Мөст сум улсын төсвийн ХО-аар баригдаж байгаа хүүхдийн цэцэрлэгийн дуусаагүй ажлын санхүүжилт 20.0 сая төгрөгийг ОНХС-аас олгосон;

- Өмнөговь аймгийн Даланзадгад сум урсгал засвар, гэрэлтүүлэг тохижилтын ажилд 15.3 сая төгрөгийн нэмэлт гэрээ байгуулсан, НТХ-ээр ахмад настан, ХБИ-ийг үнэ төлбөргүй зорчуулах 18.0 сая төгрөгийн ажилд мөнгөн дүнгүй гэрээ байгуулсан, Ханхонгор сум уурын зуухны 112.0 сая төгрөгийн засварын ажлыг 2 хувааж харьцуулалтын аргыг сонгосон, 134.0 сая төгрөгийн 3 ажлын гэрээг 5 хоногийн дотор байгуулсан, Ноён сум 19.0 сая төгрөгийн авто машиныг ШГ байгуулж, Манлай сум ЭМТ-ийн засварын ажлыг тендерийн шаардлага хангахгүй компаниар гүйцэтгүүлсэн;

- Хөвсгөл аймгийн Тариалан сум 26.0 сая төгрөгийн худгийн тоног төхөөрөмжийг ШГ байгуулсан, Рэнчинлхүмбэ сумын 40.0 сая төгрөгийн засварын ажилд 20.0 сая төгрөг нэмж баталсан, аймгийн ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр төлөвлөсөн зарим арга хэмжээг ХАА-г зохион байгуулахаас өмнө хэрэгжүүлсэн;

- Сүхбаатар аймгийн Баруун-Урт сумын Гэр хорооллын хашаа гудамжийг цэцэглэх 150.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй ажилд аймгийн ОНХС-аас 50.0 сая, сумын ОНХС-аас 100.0 сая төгрөг зарцуулахаар батлагдсаныг НТШ-аар зохион байгуулалгүй, сумын ажилгүй иргэдээр гүйцэтгүүлсэн, аймгийн ОНХС-аас 725.8 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээнд шууд гэрээ байгуулсан;

- Дорноговь аймгийн Эрдэнэ сумын нийтийн халуун усны барилга угсралтын ажлын гэрээний бүрдэл дутуу, Даланжаргалан сумын авто замын тохижилтын ажилд тендерийн шаардлага хангаагүй ААН-г шалгаруулж, гэрээ байгуулсан, Хатанбулаг сумын төвд Өвс тэжээлийн агуулах барих 73.5 сая төгрөгийн ажлыг иргэдийн бүлэгтэй гэрээ байгуулж гүйцэтгүүлсэн;

- Дундговь аймгийн Говь-Угтаал сум 12.0 сая төгрөгийн “Цахилгааны нөөц, эх үүсвэр”, 13.2 сая төгрөгийн трактор, Гурвансайхан суманд 46.7 сая төгрөгийн “Соёл спортын цогцолбор”-ын барилгын ажил, 165.3 сая “Сумын 250 квт дэд өртөө, гадна цахилгаан угсралтын ажил”-ын ХАА-г хуулийн дагуу зохион байгуулалгүй шууд гэрээ байгуулж, гүйцэтгүүлсэн;

- Завхан аймаг 35.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй Улиастай сумын усан оргилуур, ногоон байгууламж, явган хүний зам талбай бүхий байгууламж барих ажлыг иргэдийн бүлгээр ШХА аргаар гүйцэтгүүлсэн;

- Нийслэлд 293 төсөл, арга хэмжээнд ХАА зохион байгуулснаас 88 ажил буюу 30.0 хувьд тухайн оны 9 дүгээр сарын 1-нээс хойш сонгон шалгаруулалт явуулж, гэрээ байгуулсан нь Засгийн газрын 2015 оны 377 дугаар тушаалаар ТЕЗ нарт үүрэг болгосон “2015 оны 8 дугаар сарын 31-нээс хойш бараа, ажил үйлчилгээ худалдан авах гэрээ байгуулахгүй байх, 2015 оны 8 дугаар сарын 31-нээс өмнө гэрээ байгуулж, гүйцэтгэл нь бүрэн санхүүжигдээгүй арга хэмжээний зардлыг 2016 оны төсөвт тусган санхүүжүүлэх арга хэмжээ авах” гэсэн даалгаврыг биелүүлээгүй.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа ТБОНӨХБАҮХАТХ-ийг зөрчсөн 6.7 тэрбум төгрөгийн зөрчил гаргасныг аудитаар илрүүлж аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтануудад 3.2 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгуулахаар 55 албан шаардлага, 3.5 тэрбум төгрөгийн зөрчлийг дахин гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

ОНХС-ийн хөрөнгийг урсгал зардалд зарцуулсан нь “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 4.4⁵⁶, 4.5⁵⁷, 4.6⁵⁸ дахь заалтуудтай нийцэхгүй байна. Тухайлбал:

- Архангай аймгийн Хангай сум малын үүлдэр угсааг сайжруулах ажлын шатахууны зардалд 2.5 сая, Батцэнгэл сум гэрэлтүүлгийн гэрлийн үнэнд 0.7 сая нийт 3.2 сая төгрөг;

- Булган аймгийн Гурванбулаг суманд Олон нийтийн цагдааг цалинжуулахад 4.2 сая, Сэлэнгэ суманд малчны цалин шимтгэлд 4.6 сая, Гурванбулаг, Хангал, Орхон, Хутаг-Өндөр сумд автомашин худалдан авахад 85.5 сая, Хишиг-Өндөр сум Архигүй булган, Шатар, Морин хуур Дэд хөтөлбөрийн хүрээнд 3.7 сая, Бүрэгхангай сум 9 оюутан, тэмцээний зардалд 5.0 сая, орон сууц хөтөлбөрт 190.0 сая, цагаан сар, наадмын зардалд 11.0 сая, бусад зардалд 5.0 сая төгрөг зарцуулж, 2 иргэнд 1.0 сая төгрөгийн тусламж;

- Говь-Алтай аймгийн Тайшир сум гудамжны гэрэлтүүлэг, хог цэвэрлэгээний зардалд 3.1 сая, Халиун сум Ёслол хүндэтгэлийн өргөөний засварт 4.8 сая, Хөхморьт сум 9.0 сая төгрөгөөр худгуудад мотор авах зэрэгт аймгийн ОНХС-аас 365.2 сая, сумдын ОНХС-аас 87.8 сая төгрөг;

- Хэнтий аймгийн Дархан, Бор-Өндөр, Норовлин сумд, Өлзийт, ХэрлэнбаянУлаан тосгод урсгал зардалд 24.7 сая төгрөг;

- Говьсүмбэр аймаг нэг удаагийн шинжтэй сургалтад 34.2 сая, ой тэмдэглэхэд 138.2 сая, гадаад томилолтонд 33.2 сая, тэмцээн уралдаанд 55.6 сая, шагнал урамшуулалд 87.3 сая, оюутны тэтгэлэгт 12.6 сая, нийт 361.1 сая төгрөг;

- Дархан-Уул аймаг орон нутгийн төсвийн бус 8 байгууллагад 17.4 сая төгрөгийн санхүүжилт олгосон, улсын төрөлжсөн олимпиадад оролцож медаль авсан багш, сурагчдад 3.4 сая, “Ном” хөтөлбөрийн хүрээнд 12 багш, ажилтанд 0.6 сая төгрөгийн урамшуулал;

- Дорнод аймгийн Баяндун сум Соёлын төвийн хашаа, морь барианы газарт 15.0 сая, Дашбалбар сум Нийтийн зэмшилтийн гэрэлтүүлэгт 2.8 сая, Хөлөнбуйр сум Цагдаагийн албаны байрны тохижилт, гудамжны гэрэлтүүлгийн зардалд 3.5 сая, Матад сум Ахмад, залуучууд, ХБИ, ТББ-ыг дэмжих, сургуулийн халаалт, тоног төхөөрөмж зэрэгт 13.5 сая, Сэргэлэн сум сургалтын тоног төхөөрөмж, тоглоом авах зэрэгт 8.9 сая, Хэрлэн сум олимпиад, сургалт, зөвлөгөөн зэрэгт 6.2 сая, Чойбалсан сум Хүүхдийн сувиллын зардалд 0.7 сая төгрөг;

- Завхан аймаг “Жи мобайл” үүрэн телефоны сүлжээ суурилуулах ажилд 120.0 сая, аймгийн нэгдсэн эмнэлэгт 25.5 сая, Эрүүл мэндийн газарт 3.8 сая, Түдэвтэй, Шилүүстэй сумдад эх барих эмчийг тогтвор сууршилтай ажиллуулах зорилгоор тэтгэмжид 10.0 сая, олимпиад, үзэсгэлэн худалдаа зохион байгуулахад 7.1 сая, “Зөв Завхан Хүүхэд” дэд хөтөлбөрт 32.4 сая, Засаг даргын 3 тулгуурт бодлогын үргэлжлэлд 21.3 сая, “Нэг цонх”-ны үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх гэсэн ажлын зориулалтыг өөрчлөн 5.0 сая төгрөгийн хөрөнгө бэлтгэсэн, сургалт зохион байгуулахад 10.0 сая, Зэвсэгт хүчний 325-р ангид 2.0 сая;

- Өмнөговь аймгийн Даланзадгад сум 5.6 сая төгрөгийн асар майхан худалдан авсан, 9.0 сая төгрөгөөр золбин нохой устгасан, Булган сум хогийн цэгийн засварлах ажилд 23.9 сая төгрөг;

- Хөвсгөл аймаг шагнал, урамшуулал, томилолт, сургалт, спортын арга хэмжээнд 202.9 сая;

⁵⁶ “Аймаг, нийслэл, сум дүүргийн удирдлагыг хэрэгжүүлэх урсгал болон хөрөнгийн зардалд зарцуулахгүй байх”

⁵⁷ ОН-ийн төсвийн бус байгууллагад ОНХС-аас хөрөнгө зарцуулахгүй байх

⁵⁸ ОНХС-ийн хөрөнгийн буцалтгүй тусламж, дэмжлэгт зарцуулахгүй байх

- Сүхбаатар аймгийн Баруун-Урт сум гэмт хэргээс урьдчилан сэргийлэхэд 2.1 сая, СӨХ үйл ажиллагаанд 5.3 сая, нийтийн тээврийн үйлчилгээнд 10.0 сая, багуудын өдөрлөг зохион байгуулахад 8.9 сая, Түвшинширээ сум төв талбайн тохижилтын ажлын хөлсөнд 10.0 сая, ЕБС-ийн дээврийн засварт 9.5 сая, трактор худалдан авахад 19.6 сая төгрөг тус тус зарцуулсан байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдэх ажлуудын ТЭЗҮ, зураг, төсөв, өртгийн тооцоог урьдчилж гаргаагүй, зураг төсвийг гаргуулсан боловч өртгийн тооцоог эрх бүхий байгууллагаар хянуулж баталгаажуулаагүй нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁵⁹, Барилгын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.6⁶⁰ -д заасан шаардлагыг хангаагүй байна.

Дор дурьдсан нэр бүхий аймгийн удирдлага ОНХС-ийн хөрөнгийг иргэн, ААН-д эргэн төлөгдөх нөхцөлөөр зээл олгосон нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.5⁶¹ дахь заалтыг зөрчсөн байна. Тухайлбал:

- Баянхонгор аймаг ЖДҮ-г хөгжүүлэх чиглэлээр “Эрдэнэ өвөр” ХХК-д 41.2 сая, “Бат-идэр” ХХК-д 79.7 сая, “Ажбид” ХХК-д 29.6 сая, иргэн Л.Батцэнгэлд 25.8 сая, иргэн Д.Батсүхд 11.0 сая, иргэн Б.Оюунчимэгт 49.0 сая, нийт 236.3 сая төгрөгийн зээл олгосон;

- Төв аймгийн Баянчандмань сум ХХАА-ны мал хамгаалах сангаас түрээсийн гэрээгээр өгсөн хадлангийн тракторын төлбөрт 7.6 сая, цагдаагийн торгуулийн машинд 4.4 сая, Угтаал сум 9.9 сая, Эрдэнэ сум 9.4 сая төгрөгийг өвсны фондод хүүгүй бичил зээл олгосон;

- Увс аймгийн Түргэн сум иргэн Н.Дариймаад 2.5 сая төгрөгийн зээл олгосон;

- Ховд аймгийн Жаргалант сумын иргэн С.Даваасамбууд 40.0 сая, Аттилла Констракшн ХХК-д 44.6 сая, Малчин Түнш-Тавилга ХХК-д 3.0 сая, иргэн П.Буянжаргалд 3.4 сая, иргэн А.Алдархишигт 20.0 сая, Оож өргөө ХХК-д 28.0 сая, Гранд пасикал ХХК-д 3.0 сая, Ланз ХХК-д 38.1 сая, Уламдэлгэрэх төгөл хоршоонд 10.0 сая, иргэн Д.Баатаржавт 3.0 сая нийт 207.1 сая төгрөгийн зээл олгосон.

Зарим аймаг ОНХС-ийн хөрөнгөөр ойн арга хэмжээ тэмдэглэсэн нь Төсвийн тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.3.3⁶², баяр наадмын зардлыг хэтрүүлэн зарцуулсан нь Засгийн газрын 2010 оны 271 дүгээр тогтоолын 1⁶³ дэх заалтыг зөрчиж байна. Тухайлбал:

- Булган аймгийн Баян-Агт сум 90 жилийн ойн баяр наадмын арга хэмжээнд 40.0 сая, Хялганат тосгоны ойн баяр наадмын арга хэмжээнд 30.0 сая төгрөг;

- Говьсүмбэр аймаг Монголын морин спорт, уяачдын холбооны 20 жилийн ой уралдааныг аймгийн наадамтай хамт зохион байгуулахад 119.9 сая төгрөг;

- Сүхбаатар аймаг “Зүүн бүсийн хурд”-ын зардалд 85.0 сая, Баяндэлгэр сум нь сумын 90 жилийн ойн баримт кино хийлгэхэд 3.0 сая төгрөг;

- Хөвсгөл аймгийн ОНХС-аас мөсний баяр, хадны баяр, цаатан фестивалд нийт 3.8 сая төгрөг, Баянзүрх сум Бошлой хадны баярт 3.0 сая төгрөг;

- Завхан аймаг “Алтан намар-2015” урлаг спортын наадмыг зохион байгуулахад 10.0 сая, Яргуй-2015 хүүхдийн наадам зохион байгуулахад 8.0 сая төгрөг тус тус зарцуулсан;

- Өмнөговь аймаг 66.1 сая, Булган сум 5.3 сая, Хүрмэн сум 4.9 сая, Цогт-Овоо сум 4.0 сая төгрөгөөр;

- Дархан-Уул аймаг 30.0 сая, Шарын гол сум 10 сая төгрөгөөр;

- Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сум 5 сая төгрөгөөр тус тус хэтрүүлсэн

⁵⁹ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

⁶⁰ 17.1.6. энэ хуулийн 13.2, 13.3-т заасан зураг төсөлд магадлал хийлгэх;

⁶¹ “зээл олгох, санхүүгийн үр дагавар бүхий баталгаа гаргах, хохирлыг нөхөн төлөх үүрэг авахыг хориглоно”

⁶² Үндэсний их баяр наадмаас бусад баяр наадам, ойн арга хэмжээ, шашны зан үйлийн болон ёслолын зардал

⁶³ үндэсний их баяр наадмын арга хэмжээнд зориулан төсвөөс гаргах санхүүжилтийн жишиг дээд хэмжээг аймагт 10.0 (арван) сая төгрөг, суманд 5.0 (таван) сая төгрөг байхаар тус тус тогтоож...

2.3. ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг бүртгэл тайланд бүрэн тусгаагүй, төсөл, арга хэмжээг хүлээн авах комисс хангалтгүй ажилласан байна

ОНХС-ийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийг бүртгэл тайланд тусгаагүй нь НББТХ-ийн 9 дүгээр зүйлийн 9.1⁶⁴, “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 8.6⁶⁵ дахь заалтыг биелүүлж ажиллаагүй байна. Тухайлбал:

- Архангай аймаг нийт 108.5 сая төгрөгийн 5 ажлыг бүртгэл тайланд тусгаагүй;
- Орхон аймгийн Баян-Өндөр сумын 41.6 сая төгрөгийн явган хүний зам, 18.4 сая төгрөгийн үерийн далан, 19.9 сая төгрөгийн шугам хоолой, 49.9 сая төгрөгийн Цахим сум интернэт холбоо, 27.0 сая төгрөгийн мастер төлөвлөгөө, Баянцагаан багийн 996.3 сая төгрөгийн ИШС-г бүртгэлд тусгаагүй, Жаргалант сум Малжуулах хөтөлбөрөөр 27.3 сая төгрөгийн малыг иргэдэд эргэн төлөгдөх нөхцөлтэйгээр олгосныг сумын санхүүгийн тайланд авлагаар бүртгээгүй;
- Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын Иргэний танхимд 1.9 сая төгрөгөөр тоног төхөөрөмж авсан нь баримтаар нотлогдоогүй;
- Говь-Алтай аймгийн Баян-Уул, Дэлгэр, Жаргалан, Тайшир, Төгрөг, Халиун, Хөхморьт, Цээл, Чандмань, Шарга, Эрдэнэ зэрэг сумд 463.9 сая төгрөгийн өртөгтэй 24 хөтөлбөр, төсөл арга хэмжээг НББ-д тусгаагүй, 6 хөтөлбөр, төсөл арга хэмжээний өртгийг 34.9 сая төгрөгөөр бууруулж дутуу орлого авсан;
- Говьсүмбэр аймгийн Шивээговь сумын 3 дугаар сургуулийн сантехникийн 4.9 сая, 3 дугаар цэцэрлэгийн тохижилтийн 9.9 сая төгрөгийн ажлыг бүртгэлд тусгаагүй;
- Баян-Өлгий аймгийн Бугат сум 11.7 сая төгрөгийн хөрөнгийг, Булган сум 126.0 сая төгрөгийн гүүр, Ёлт бага сургуулийн 8.0 сая төгрөгийн их засварын ажлыг бүртгэлд тусгаагүй;
- Баянхонгор аймгийн малжуулах төслийн хүрээнд нийт 650.3 сая төгрөгийг эргэн төлөгдөх нөхцөлөөр олгосон боловч бүртгэл тайланд авлагаар тусгаагүй;
- Сэлэнгэ аймаг 9 төрлийн 1,274.3 сая төгрөгийн ажил, Баруунбүрэн, Сайхан сумын 113.0 сая төгрөгийн цахилгааны шугам татах ажлыг бүртгэлд тусгаагүй;
- Төв аймгийн Зуунмод сумын 193.2 сая төгрөгийн ахуй үйлчилгээний барилга, 4 дүгээр сургуулийн 321.0 сая төгрөгийн цэвэрлэх байгууламж, 132.2 сая төгрөгийн гудамж төслийн ажил, Батсүмбэр сумын 45.0 сая төгрөгийн 4 худаг, Цээл сумын 10.0 сая төгрөгийн бөхийн дэвжээ, Баянцогт сум 14.2 сая төгрөгийн ЦТП дэд өртөөний ажлын урьдчилгаа, Зуунмод сум 21.7 сая төгрөгийн тоног төхөөрөмж, Бүрэн сум 13.5 сая төгрөгийн цагдаагийн кабон, гамшигтай тэмцэх байгууллагын төслийн 50.0 сая, сургуулийн барилгын зургийн үнэ 10.0 сая, Эрдэнэсант сум ЭМТ-ийн барилгын өргөтгөлийн 15.0 сая, Баянжаргалан, Дэлгэрхаан, Алтанбулаг, Сүмбэр, Цээл, Баяндэлгэр, Баян, Эрдэнэ, Заамар сумд нийт 102.5 сая төгрөгийн ерөнхий төлөвлөгөөг бүртгэлд тусгаагүй;
- Увс аймгийн Баруунтуруун сум спорт заалны засварын зураг төсөв 3.0 сая, аймгийн ЗДТГ-ын их засварын 15.0 сая, Биеийн тамир спортын газрын их засвар 16.0 сая, Тариалан сумын төвийн сайжруулсан шороон зам 10.0 сая, худгийн засвар 2.0 сая, нийт 12.0 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлд тусгаагүй;
- Дорноговь аймаг ЦЭХ-ний угсралтын ажлын 260.0 сая, Сайншанд сум ЦДАШ, дэд станцын 94.5 сая, Замын-Үүд сум 77.7 сая төгрөгийн гэрэлтүүлэг, 758.0 сая төгрөгийн Спорт цогцолбор барилга, 3 сургууль 8 цэцэрлэгийн нийт 4.9 сая төгрөгийн камержуулалтыг бүртгэлд тусгаагүй;
- Завхан аймгийн Асгат, Баянтэс, Их-уул, Нөмрөг, Улиастай сумд нийт 63.8 сая төгрөгийн хөрөнгө бүртгэлд тусгаагүй;
- Дундговь аймаг 10.0 сая төгрөгийн тоног төхөөрөмж, Өндөршил сум 4.1 сая төгрөгийн тоног төхөөрөмж бүртгэлд тусгаагүй;
- Дорнод аймаг 75.8 сая төгрөгийн явган зам, гэрэлтүүлэг бүртгэлд тусгаагүй;
- Хөвсгөл аймаг 689.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй хяналтын камерыг бүртгэлд тусгаагүй;
- Ховд аймаг 270.0 сая төгрөгийн тэмс боловсруулах үйлдвэр, 7 суманд хэрэгжүүлсэн 80.0 сая төгрөгийн өртөг бүхий шилэн кабель бүртгэлд тусгаагүй;

⁶⁴ Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрөнгө, өр төлбөрөө нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэлж дансанд тусгана

⁶⁵ “ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгэнэ”

- Булган аймгийн Бүрэгхангай суманд хэрэгжүүлсэн 11.3 сая төгрөгийн Төвийн интернэтийн өргөтгөл, Гурванбулаг сумын 46.9 сая төгрөгийн музейн үзмэр бүртгэл тайланд тусгаагүй байна.

Аудитаар ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн хөрөнгө оруулалтыг орон нутгийн өмчид бүртгээгүй 10.5 тэрбум төгрөгийн зөрчилтэй холбогдуулан аймаг, нийслэлийн Засаг дарга нарт 9.1 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгуулахаар 163 албан шаардлага, 1.4 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмж хүргүүлээ.

ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн төсөл, арга хэмжээ дутуу буюу чанаргүй хийгдэх, санхүүжилтийг илүү олгох, ажил гүйцэтгэж дууссан ч ашиглах боломжгүй байгаа нь Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3⁶⁶, 16 дугаар зүйлийн 16.5.2⁶⁷, 41 дүгээр зүйлийн 41.2.3⁶⁸, Засгийн газрын 2012 оны 151 дүгээр тогтоол “Барилгын ажлыг эхлүүлэх, үргэлжлүүлэх, ашиглалтанд оруулах дүрэм”-ийн 4.12⁶⁹, 4.13⁷⁰, Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийн журам”-ын 3.25⁷¹ дахь заалтуудыг биелүүлээгүй байна. Тухайлбал:

- Архангай аймаг ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг хүлээн авах комиссын бүрэлдэхүүнд мэргэжлийн хүн оролцуулаагүй;

- Говь-Алтай аймаг 86.4 сая төгрөгийн 5 төсөл арга хэмжээ чанаргүй хийгдсэн ажлыг комиссын дүгнэлтээр хүлээн авсан;

- Баянхонгор аймгийн Баян-Овоо сумын төв цэнгэлдэх хүрээлэнгийн ажлын санхүүжилтийг батлагдсан төсвөөс 42.8 сая төгрөгөөр илүү олгосон, “Хөх бүрдний чулууд” ХХК, “Тэвшийн рашаан”, “Санаачилга” ХХК, “Шандаст хонгор” ХХК, “Шандаст хонгор” ХХК зэрэг нийт 15 гүйцэтгэгч гэрээний хугацаандаа ажлаа дуусгаагүй;

- Ховд аймгийн Дарви сум Сутай омгын хонины хээлтэгч бий болгох ажилд 19.0 сая төгрөг олгосон ч нийлүүлэх малыг одоог хүртэл хүлээлгэн өгөөгүй;

- Өвөрхангай аймгийн Арвайхээр, Богд сумын цэцэрлэгт хүрээлэнгийн тохижилт, Сант сумын цэвэрлэх байгууламжийн барилга угсралт, Уянга сумын эмнэлгийн барилгын засвар, Баян-Өндөр сумын гэр цэцэрлэгийн тохижилт, Сант сумын төрийн албан хаагчийн орон сууцны барилга, Богд суманд трактор нийлүүлэх, Зүүнбаян-Улаан сумын цахилгааны шугамын засварын ажлууд чанаргүй, дутуу хийгдсэн байхад санхүүжилтийг бүрэн олгосон;

- Говьсүмбэр аймгийн Боржигин чуулгын барилгын их засварын ажлыг “Фамилисон” ХХК 256.8 сая төгрөгөөр гүйцэтгэсэн боловч чанаргүй хийгдсэн, зарим ажлууд огт хийгдээгүй байхад комисс хүлээн авсан;

- Төв аймгийн Сүмбэр сумын 100 хүүхдийн цэцэрлэгийн барилгын гэрээний хугацаа хэтэрсэн, ажлын гүйцэтгэл дутуу байхад санхүүжилтийг бүрэн олгосон, Өгөөмөр Уул ХХК нь ОНХС болон улс, орон нутгийн төсвийн ХО-аар хийгдэх 342.0 сая төгрөгийн 6 ажлыг зэрэг гүйцэтгэх гэрээ байгуулснаар ОНХС-ийн хөрөнгөөр хийгдсэн 105.0 сая төгрөгийн ажлууд хугацаа хэтэрсэн, Баянцагаан сумын худаг засварын ажил, цаг уурын хашааг шинэчлэх ажлыг гэрээний хугацаанд гүйцэтгээгүй, Цээл суманд 2014 онд шинээр худаг гаргах ажлын санхүүжилтийн 86.0 хувийг олгосон боловч ажил нь эхлээгүй, хугацаа хэтэрсэн;

- Хөвсгөл аймгийн Цагааннуур сумын 24.3 сая төгрөгийн “Морь уралдааны зам, баяр наадмын талбай засварлах” ажлын чанар хангалтгүй, Галт суманд баригдсан халуун усны барилга зураг, төсвийн дагуу хийгдээгүй, захиалагчийн хяналт тавиагүй, ашиглалтын шаардлага хангаагүй, Төмөрбулаг сумын замын ажил хийгдээгүй, ЭМТ-ийн барилгын их засварын ажлыг дутуу гүйцэтгэсэн;

⁶⁶ Төсвийн ерөнхийлөн захирагч өөрийн эрхлэх асуудлын төсвийн орлого, зарлагын зүй зохистой, үр ашигтай байдал, үр дүнгийн гүйцэтгэлийг хангаж, өөрт хамаарах төсвийн гүйцэтгэлийн биелэлтийг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, тухайн шатны ИТХ, ЗГ, УИХ-ын өмнө бүрэн хариуцна

⁶⁷ батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих;

⁶⁸ төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж, тайлагнах

⁶⁹ Комисс нь дараахь эрх, үүрэгтэй

⁷⁰ Захиалагч буюу зөвлөх үйлчилгээ эрхлэгч, гүйцэтгэгч нь дараахь эрх үүрэгтэй

⁷¹ Барилга, байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийн зардлыг хооронд нь шилжүүлэх, батлагдсан нэр, байршлыг солих, хүчин чадлыг өөрчлөх, хуулиар батлагдсан төсөвт өртгийг хэтрүүлэн тендер зарлах, гэрээ байгуулах, санхүүжүүлэхийг хориглоно.

- Сүхбаатар аймгийн Түмэнцогт суманд гүйцэтгэсэн хүүхдийн талбайн ажил, соёлын төвийн засварын өргөтгөлийн ажлын гүйцэтгэл дутуу байхад комисс хүлээн авч, санхүүжилтийг бүрэн олгосон, Халзан суманд хийгдсэн наадмын талбайн засварын 4.5 сая төгрөгийн ажил дутуу хийгдсэн байхад хүлээн авсан, Уулбаян сум 50.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй явган хүний замын ажлын 21.4 сая төгрөгийн ажил хийгдээгүй, 10.0 сая төгрөгийн цэцэрлэгт хүрээлэнгийн 2.5 сая төгрөгийн ажил дутуу хийгдсэн байхад комисс хүлээн авч санхүүжилтийг бүрэн олгосон;

- Дундговь аймгийн Баянжаргалан сумын 16.0 сая төгрөгийн “Ногоон байгууламж”-ийн хашаа, Дэрэн сумын 21.7 сая төгрөгийн “Ахуйн үйлчилгээний барилгын засвар”, Говь-Угтаал сумын 9.9 сая төгрөгийн “Соёлын өвийг хамгаалах” ажил, Хулд сумын 3.0 сая төгрөгийн “Цэцэрлэгийн гадна завсар”, Сайнцагаан сумын 6.0 сая төгрөгийн “Хадагтын рашаан”-ны худгийн байшин барих ажлууд дутуу, чанаргүй хийгдсэн ч санхүүжилтийг бүрэн олгосон, Дэрэн сумын “Ахуйн үйлчилгээний барилга”, Өлзийт сумын хүнс, цайны газрын барилгыг зориулалтын дагуу ашиглаагүй;


- Дорноговь аймгийн Даланжаргалан сумын явган хүний зам, гудамжны гэрэлтүүлгийн ажилд 37.8 сая, Хөвсгөл сумын Соёл спорт цогцолбор барих ажлын зураг төсвийн үнэд 684.3 мянган төгрөг илүү олгосон;

- Увс аймгийн Өлгий сум 2014 оны 8 сард ашиглалтанд оруулахаар гэрээ байгуулсан “Б.Гиваан баатрын хөшөөт талбайг барих” ажил дуусаагүй, Малчин суманд 30.0 сая төгрөгийн өртөгтэй наадмын талбайн засварын ажлыг комисс хүлээж авсан боловч дээвэр нь хуурч нурсан;

- Завхан аймгийн Улиастай сумын Жаргалант багийн барилгын ажилд 97.0 сая төгрөгийг илүү олгосон, Ургамал сумын төв талбайн тохижилтын ажилд санхүүжилтийн 70 хувийг олгосон ч ажил эхлэл төдий, Эрдэнэхайрхан сумын хөв цөөрөм байгуулах 15.9 сая төгрөгийн ажил чанаргүй хийгдсэн байна.

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, гүйцэтгэл зарим талаар хангалтгүй, 47.9 тэрбум төгрөгийг холбогдох хууль, журам, зааврыг зөрчиж зарцуулсан байна.

Аудитаар илэрсэн зөрчил, эх үүсвэрийн харьцааг графикаар харуулбал:




ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн жагсаалтыг хүснэгтээр үзүүлбэл: /сая.төг/

Зөрчлийн ангилал										
№	Аймаг, нийслэл	Нийт илэрсэн зөрчлийн дүн /сая.төг/	Зориулалт бусаар зарцуулсан	Иргэдийн саналаар дэмжигдээгүй ажлыг жагсаалтад оруулж, санхүүжүүлсэн	Худалдан авах ажиллагааны журам зөрчсөн	Дутуу буюу чанаргүй хийгдсэн, хугацаа хэтэрсэн	Бүртгэл тайланд тусгаагүй	ТЭЗУ, зураг төсөв нь батлагдаагүй 3Х тавиагүй	төсөвт өртөгөөс илүү санхүүжүүлсэн	Хэрэгжээгүй, санхүүжилт ээ аваад ажлаа хийгээгүй
1	Архангай	528.5	2.5	315.9		94.6	108.5			7.0
2	Баян-Өлгий	434.3	19.7	170.2	55.9		145.7	40.0	2.8	
3	Баянхонгор	2,268.1	729.8	67.9		225.5	1,009.6	8.2	220.9	6.3
4	Булган	1,018.2	183.0	163.8	263.2	42.8	215.0	140.0		10.0
5	Говь-Алтай	3,540.5	252.2	652.8	322.1	90.1	472.0	1,404.0	300.8	47.1
6	Говьсүмбэр	1,594.9	534.5	503.8	198.1	333.0	25.0		0.6	
7	Дархан-Уул	13.7				12.7				0.96
8	Дорноговь	2,290.3	121.5	115.7	399.9		1,239.3	413.3	0.6	
9	Дорнод	786.3	50.6	544.9	115.0		75.8			
10	Дундговь	2,533.2	197.9		237.2	39.6	1,798.0	261.0		
11	Завхан	897.7	397.2	113.4	35.0	182.2	69.1	68.0	4.9	28.0
12	Орхон	2,139.0	956.4	2.2			1,180.4			
13	Өвөрхангай	707.7	232.0			232.0	215.6			28.1
14	Өмнөговь	9,558.9	15.1	9,086.8	331.0	24.9			101.1	
15	Төв	3,657.3	168.7	30.4		749.3	437.1	2,180.6	7.0	84.2
16	Ховд	359.2		104.6	78.5	90.1		30.0		56.0
17	Хөвсгөл	4,467.6	1,435.2	845.3			689.0	1,493.1	5.0	
18	Хэнтий	121.4	27.5	60.0	32.0		2.0			
19	Сүхбаатар	2,272.4	36.4	50.8	927.8	51.0	55.0	1,149.8	2.0	
20	Сэлэнгэ	2,169.7	-	124.0	494.5		1,387.3	137.1	15.4	11.4
21	Увс	204.4	20.9	-	57.0	77.9	46.6		2.0	
22	Нийслэл	6,306.4	4.9	426.5	3,187.2	1,309.3	1,346.6		31.9	
	ДҮН	47,869.7	5,386.0	13,379.0	6,734.4	3,554.6	10,517.2	7,324.6	695.0	279.1

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжигдсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд хийсэн аудитаар нийт 47.9 тэрбум төгрөгийн зөрчил илэрсэн нь нийт санхүүжүүлсэн хөрөнгийн 35.8 хувийг эзэлж байгаа бөгөөд 0.5 тэрбум төгрөгийн төлбөрийн акт, 32.6 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах албан шаардлага, 14.8 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах зөвлөмжийг холбогдох байгууллага, албан тушаалтануудад хүргүүлэв.

ОНХС-ийн зарцуулалтад хийсэн аудитаар илэрсэн зөрчлийг өмнөх онуудтай харьцуулбал:



ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитаар илэрсэн зөрчил өмнөх оноос 39.3 тэрбум төгрөгөөр, бүрдүүлсэн эх үүсвэртэй нь харьцуулахад 6 хувиар буурсан боловч илэрч байсан зөрчлүүд арилахгүй давтагдаж байгаа нь орон нутгийн удирдлагууд сангийн хөрөнгөөр гүйцэтгэх төсөл, арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэхдээ холбогдох хууль, журам, зааврыг мөрдөхгүй, өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг арилгах талаар тодорхой арга хэмжээ авч ажиллаагүй, дээд шатны удирдлагаас зөрчил гаргасан албан тушаалтнуудтай хариуцлага тооцохгүй байгаатай холбоотой байна.

БҮЛЭГ 3. ОНХС-ИЙН ХӨРӨНГӨӨР САНХҮҮЖҮҮЛСЭН ТӨСӨЛ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ТАВИХ ХЯНАЛТ ХАНГАЛТГҮЙ БАЙНА

3.1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн зарим төсөл, арга хэмжээний захиалагчийн хяналт хангалтгүй байгаа нь ажлын чанарт сөргөөр нөлөөлж байна

ОНХС-ийн хөрөнгөөр санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтэд ТБОНӨХБАҮХАТХ-ийн 46 дугаар зүйлийн 46.1.6⁷², Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар баталсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.4⁷³, 7.1⁷⁴, 9.2⁷⁵-т заасны дагуу захиалагч гэрээний биелэлтийг хянаж, дүгнэж хэвшээгүй, сумдад ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж байгаа төсөл, арга хэмжээний гүйцэтгэлд захиалагчийн хяналтыг ихэвчлэн ЗДТГ-ын ажилтнууд тавьж байна.

Эдгээр ажилтнууд нь захиалагчийн хяналт тавихад мэргэжлийн чадвар дутмагаас гүйцэтгэгч байгууллагад шаардлага бүрэн тавьж чаддаггүй, зайлшгүй шаардлагатай багаж, тоног төхөөрөмжгүй, захиалагчийн хяналтын зардал байхгүй, зарим аймгийн удирдлага энэ зардлыг зориулалтын дагуу зарцуулдаггүйгээс ОНХС-аас санхүүжүүлсэн төсөл, хөтөлбөр үр дүнгүй, төсөл, дутуу, хугацаандаа хэрэгждэггүй зөрчил давтагдахад хүргэж байна. Тухайлбал:

- Архангай аймаг хяналт хэрэгжүүлээгүй;
- Говь-Алтай аймагт өмнөх онд хэрэгжсэн 537.9 сая төгрөгийн өртөгтэй хөрөнгүүдийн арчлалт, хамгаалалт сулаас зарим хөрөнгө ашиглах боломжгүй болсон;
- Баянхонгор аймаг хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явц, үр дүнг хянаж, үнэлгээ хийгээгүй;
- Сэлэнгэ аймгийн Түшиг, Жавхлант сумын ИТХ-ын дэргэд “Хяналтын хороо” байгуулаагүй, Мандал сумын ИТХ-аас хяналтын хороо байгуулсан боловч хяналт хийгдээгүй, Баянгол, Зүүнбүрэн, Цагааннуур, Хушаат сумаас бусад сумдын ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороодын хийсэн хяналт шалгалт хангалтгүй, Зүүнбүрэн сумаас бусад сумд, аймгийн Засаг дарга нар ЗД-ын зөвлөлийн хурлаар хөндлөнгийн болон дотоод аудитын тайланг хэлэлцээгүй;
- Ховд аймагт захиалагчийн хяналт хангалтгүй, Буянт тэгш үйл ХХК-ийн барьсан 4, 8 дугаар цэцэрлэгүүдийн тохижилтын ажлууд зураг төсвийн дагуу хийгдээгүйг улсын комисс хүлээн авсан;
- Хөвсгөл аймгийн Мөрөн суманд суурилуулсан хяналтын камерууд захиалагчаас өгсөн техникийн шаардлага хангахгүй, Хатгал тосгоны 150 хүүхдийн цэцэрлэгийн ажлыг 488.5 сая төгрөгөөр “Хөвсгөл Монтрэйвл” ХХК зураг төсвөөс зөрүүтэй гүйцэтгэсэн, Шинэ-Идэр сумын цахилгаан дамжуулах шугамын ажлын гүйцэтгэл зураг төсвөөс зөрүүтэй, одоогоор ашиглагдаагүй;
- Сүхбаатар аймагт Цэвэр усны 900 м шугам, ус өргөх цамхаг, уурын зуухны яндангийн шинэчлэлийн ажлыг 366.7 сая төгрөгөөр “Их модун” ХХК гүйцэтгэсэн боловч захиалагчийн хяналт хийгдээгүй.



Гадна фасад хуурсан байдал

- “Баярс Констракшн” ХХК-ийн хийж гүйцэтгэсэн ХУД-ийн 10 дугаар хорооны 230 дугаар цэцэрлэгийн барилгын гадна фасад ховхорч унасан, дээврийн хонгилын 2 хаалганы завсраар ус гоожсон, угаалгын өрөөнд агааржуулалт хийгдээгүй.

⁷² бараа, ажил, үйлчилгээ худалдан авах гэрээний үүргийн биелэлтэд хяналт тавих

⁷³ Тухайн шатны ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо нь сайн дурын идэвхтэн иргэд, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ОНХС-аас хэрэгжсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээний үр дүнд хяналт тавьж, үнэлгээ хийнэ

⁷⁴ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад ...тухайн орон нутгийн ИТХ-ын дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллана.

⁷⁵ ОНХС-аас оруулж байгаа хөрөнгө оруулалт, хэрэгжих хөтөлбөр, төсөл, арга хэмжээнд гүйцэтгэлийн, санхүүгийн хяналт шалгалтыг дотоод аудитын алба хэрэгжүүлнэ.

СХД-ийн 7 дугаар хороонд "Ньюгранд" ХХК-ийн хийж гүйцэтгэсэн тоглоомууд, сүүдрэвч, гэрэлтүүлэг нь эвдэрсэн.



Байгуулсан талбай дундуур машин зам гарснаас тоглоомууд эвдэрсэн



Сүүдрэвч тоногдож эвдэрсэн

БЗД-ийн 17 дугаар хорооны 8 дугаар хэсэг 13 дугаар гудамжинд "Цагаан цамхаг" ХХК-ийн гүйцэтгэсэн 200 м явган хүний замын 11 м хавтан эвдэрч, 48 хашлага унасан



Явган замын хашлага унасан



Явган зам эвдэрсэн



Увс аймгийн Малчин суманд 30.0 сая төгрөгийн өртөгтэй наадмын талбайн засвар чанаргүй хийгдсэн



Сүхбаатар аймгийн Уулбаян сумын 50.0 сая төсөвт өртөгтэй явган хүний зам 1500м² дутуу хийгдсэн

ОНХС-ийн хөрөнгийн зарцуулалтад хийсэн аудитаар нийт 3.6 тэрбум төгрөгийн төсөл, арга хэмжээг дутуу буюу чанаргүй гүйцэтгэснийг илрүүлж аймаг, нийслэлийн Засаг дарга, холбогдох байгууллага, албан тушаалтнуудад 3.3 тэрбум төгрөгийн зөрчил арилгуулах 70 албан шаардлага, 17.0 сая төгрөгийг төсөвт төлүүлэх 8 акт, 300.0 сая төгрөгийн зөрчлийг дахин гаргахгүй байх зөвлөмж хүргүүлэв.

3.2. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, хөрөнгийн зарцуулалтын мэдээллийг олон нийтэд мэдээлсэн байна

ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний мэдээллийг аймаг, нийслэл, сум, дүүргүүд мэдээллийн самбар болон байгууллагын цахим хуудаст байршуулж иргэдэд танилцуулсан байна.


3.3. Орон нутгийн удирдлагууд өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг арилгах талаар дорвитой арга хэмжээ авч ажиллахгүй байна

ОНХС-ийн 2013, 2014 оны зарцуулалтад хийсэн нийцлийн аудитаар өгсөн зөвлөмж, акт албан шаардлагын хэрэгжилт хангалтгүй, орон нутгийн удирдлагууд ОНХС-ийн орлогын төлөвлөлт, хуваарилалт, бүрдүүлэлт болон сангийн хөрөнгийн зарцуулалтад тавих хяналтыг сайжруулах талаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлэхэд тодорхой ажил зохион байгуулаагүйгээс өмнөх аудитаар илэрсэн зөрчил дутагдал арилахгүй, давтан гарсаар байна. Тухайлбал:

- Нийслэлд 69 зөвлөмж өгснөөс 47.8 хувь буюу 33 зөвлөмжийг хэрэгжүүлж, 52.2 хувийг хэрэгжүүлээгүй “Иргэдийн саналаар дэмжигдээгүй төсөл, арга хэмжээг жагсаалтад оруулж, санхүүжүүлсэн”, “Худалдан авах ажиллагааны журам зөрчсөн”, “Бүртгэл тайланд тусгаагүй” гэсэн зөрчил давтагдсан;

- Аудитаар тавигдсан актыг Дорнод аймаг 97.6 хувийг, Говьсүмбэр аймаг 93.7 хувийг, Хөвсгөл аймаг 77.6 хувийг, Завхан аймаг 41.0 хувийг, Булган аймаг 37.4 хувийг, Төв аймаг 34.0 хувийг, Баянхонгор аймаг 27.9 хувийг, Ховд аймаг 10.9 хувийг барагдуулаагүй, албан шаардлагыг Хөвсгөл аймаг 60 хувийг, Дорноговь аймаг 42.9 хувийг, Булган аймаг 32.2 хувийг биелүүлээгүй, өгөгдсөн зөвлөмжийг Завхан аймагт 60.2 хувь, Сэлэнгэ аймагт 60.0 хувь, Говь-Алтай аймагт 55.6 хувь, Ховд аймагт 41.7 хувь, Булган аймагт 35.8 хувь, Говьсүмбэр аймагт 27.0 хувийг хэрэгжүүлээгүй байна.

ОНХС-ийн зарцуулалтад өмнөх онуудад хийсэн аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилтийг графикаар үзүүлбэл:



Орон нутгийн удирдлагууд өмнөх аудитаар илэрсэн зөрчилд тавьсан актын 25.9 хувийг, өгсөн албан шаардлагын 14.6 хувийг, зөвлөмжийн 19.3 хувийг биелүүлээгүй байна.

3.4. Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг бүрэн байршуулаагүй байна

Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.2.2-т “Орон нутгийн хөгжлийн сан”-ийн төсөв санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагналтай холбоотой мөнгөн болон бусад гүйлгээг хамруулахаар заасны дагуу мэдээллийг самбарт байршуулсан ч ЗГ-ын 2014 оны 384 дүгээр тогтоолын хавсралт 11-д тусгасан ОНХС-ийн төсөв, гүйцэтгэлийн мэдээллийг Шилэн дансны цахим

хуудсанд байршуулаагүй нь дээрх хуулийн 6 дугаар зүйлийн 6.3⁷⁶, 6.3.9⁷⁷ дэх заалтыг биелүүлээгүй байна. Тухайлбал:

- Дорноговь аймаг ОНХС-ийн төлөвлөгөө, гүйцэтгэл, санхүүжилтийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн системд, Даланжаргалан, Замын-Үүд, Мандах, Өргөн сум санхүүжилтийн мэдээллийг, Сайхандулаан сум тендер, санхүүжилтийн мэдээллийг байршуулаагүй;
- Дундговь аймаг Шилэн дансны 2015 оны шилэн дансны мэдээллийг 2016 оны 1 сард нөхөн оруулсан, Сайнцагаан сум баталсан хүснэгтэнд мэдээлээгүй, Цагаандэлгэр сум шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд огт мэдээлээгүй;
- Сүхбаатар аймгийн Асгат, Дарьганга, Сүхбаатар, Түвшинширээ, Түмэнцогт сумдууд мэдээллийг shilendans.gov.mn сайтад байршуулаагүй;
- Өвөрхангай аймагт орон нутгийн хөгжлийн сангийн төлөвлөгөө, гүйцэтгэлийн талаарх мэдээллийг 84.2 хувь нь байршуулсан;
- Сэлэнгэ аймгийн Алтанбулаг, Хүдэр сумдууд мэдээллийг огт оруулаагүй;
- Төв аймаг тендерийн ерөнхий мэдээллийн 7 дугаар маягтаар 8 хөрөнгө оруулалт, төсөл, хөтөлбөрийн мэдээллийг байршуулж, бусдыг нь байршуулаагүй, 19 дүгээр маягтаар 10 сая төгрөгнөөс дээш үнийн дүнтэй санхүүжилтийн мэдээллээ байршуулаагүй;
- Ховд аймгийн Мөст, Булган, Манхан, Мянгат зэрэг 13 сумдад шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалтгүй байна.

Аймаг, сумдад ОНХС-аар хийгдэх хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний төлөвлөлт, хэрэгжилтийн байдалд Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1⁷⁸, Сангийн сайдын 2014 оны 43 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн заавар”-ын 9.1⁷⁹, 9.2⁸⁰, 9.4⁸¹-д заасан үүргийг холбогдох албан тушаалтнууд хангалтгүй биелүүлсэн байна.

⁷⁶ Энэ хуулийн 6.1.2-т заасан мэдээлэл дараах байдлаар илэрхийлэгдсэн байна:

⁷⁷ Орон нутгийн хөгжлийн сангийн гүйцэтгэл.

⁷⁸ “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, .. хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах...”

⁷⁹ ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлж буй хөрөнгө оруулалт, хөтөлбөр төсөл арга хэмжээний төлөвлөлт, санхүүжилт, гүйцэтгэлийн явцад хяналт шалгалтын байгууллагууд, тухайн орон нутгийн ИТХ-н дэргэдэх Хяналтын хороо, иргэд, иргэний нийгмийн байгууллагууд хяналт тавьж ажиллана.

⁸⁰ “ОНХС-аас оруулж байгаа ХО, хэрэгжих хөтөлбөр, төсөл арга хэмжээнд гүйцэтгэлийн, санхүүгийн хяналт шалгалтыг дотоод аудитын алба хэрэгжүүлнэ”

⁸¹ аймаг, сумдын ИТХ-ын дэргэдэх хяналтын хороод, иргэд, иргэний нийгмийн байгууллагуудтай хамтран ОНХС-аас хэрэгжүүлсэн хөтөлбөр, төсөл арга хэмжээний үр дүнг хянаж, үнэлгээ хийх

Холбогдох байгууллагын санал:

	ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАРТ
МОНГОЛ УЛСЫН САНГИЙН ЯАМ	
15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг, С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр, Утас/факс: (976-51) 26-74-68, http://www.mof.gov.mn	
2016.06.02	№ 3-4/3673
танай 2016.05.23	-ны № 2/901 -т
Санал өгөх тухай	
Орон нутгийн хөгжлийн сангийн 2015 оны зарцуулалтад хийсэн нийцлийн аудитын тайлангийн төсөлтэй танилцаад дараах саналыг хүргүүлж байна. Үүнд: 1.Үндсэн мэдээлэл хэсэгт "ОНХНС-аас аймаг, нийслэлийн ОНХС-д олгосон орлогын шилжүүлгийн гүйцэтгэл нь батлагдсан дүнгээс 16.7 хувиар <u>буурсан</u> байна" гэснийг "ОНХНС-аас аймаг, нийслэлийн ОНХС-д олгосон орлогын шилжүүлгийн гүйцэтгэл нь батлагдсан дүнгээс 16.7 хувиар <u>дутуу</u> байна" гэж өөрчлөн найруулах нь зүйтэй. 2.БҮЛЭГ 1-ийн 1.1-д "Сангийн яам нь 2015 оны ОНХНС-ийн эх үүсвэрийг улсын хэмжээнд төлөвлөхдөө... аймаг, нийслэлээс ОНХС-ийн эх үүсвэрийн тооцооллыг авч төсвийн төсөлд тусгаагүй ..." хэсэгт Төсвийн тухай хуулийн тохирохгүй заалтыг үндэслэл болгосон байна. Мөн Төсвийн тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1-д заасан ОНХНС-ийн эх үүсвэрийн тооцоололд аймаг, нийслэлээс ирүүлэх төсвийн санал нөлөөлөхгүй тул төсөв батлагдах хугацаанд урьдчилсан санал ирүүлэх шаардлагагүй юм. Харин орон нутгийн төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайланд ОНХС-ийн хэрэгжилтийг цаашид хэрхэн тайлагнах талаар тусгах нь зүйтэй. 3.Мөн Сангийн сайдад өгсөн "...аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангаас сум, дүүрэгт хөрөнгө хуваарилахад ашиглагдах сумын хөгжлийн индексийг тооцож нийтэд зарлах" зөвлөмжид дараах саналтай байна.Үүнд: Засгийн газрын 2014 оны 242 дугаар тогтоолоор "Сумын хөгжлийн индекс тооцох аргачлалыг баталсан бөгөөд 2013 оны индексийг 2014 оны IY улиралд багтаан зарлах, цаашид 2 жилд 1 удаа уг индексийг тооцон зарлаж байхыг Эдийн засгийн хөгжлийн сайдад даалгасан байдаг. Өөрөөр хэлбэл, Засгийн газраас даалгасны дагуу сумын хөгжлийн индексийг шинэчлэн тооцож зарлах ээлжит хугацаа 2016 онд дуусгавар болох бөгөөд энэхүү хугацааг дуусаагүй байхад сумын хөгжлийн индексийг Сангийн яам тооцож зарлаагүй байгаа талаар нийцлийн аудитын тайланд дурдагдсан нь учир дутагдалтай гэж үзэж байна. Нөгөөтэйгүүр, Эдийн засгийн хөгжлийн яам 2014 онд татан буугдахад орон нутгийн хөгжлийн индексийг тооцох нийтлэг аргачлалыг боловсруулах, индексийг тооцох, шинэчлэн тогтоох, нийтэд зарлаж байх чиг үүрэг төрийн аль нэгэн байгууллагад шилжиж очилгүйгээр орхигдсон байдаг.	

004699

Засгийн газрын 2014 оны 402 дугаар тогтоолоор батлагдсан Сангийн яамны үйл ажиллагааны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөрт орон нутгийн хөгжлийн индексийг тооцох чиг үүрэг Сангийн яамны үйл ажиллагааны зорилтод тусгагдаж чадаагүй.

Түүнчлэн, Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачлан боловсруулж 2016 оны 02 дугаар сарын 08-ны өдөр Улсын Их Хуралд өргөн барьсан Төсвийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлийн 1-д аймаг, нийслэлээс сум, дүүрэгт Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хуваарилахад сумын хөгжлийн индексийг ашиглахгүй байхаар тусгасан.

Иймд аймаг, нийслэлийн орон нутгийн хөгжлийн сангаас хөрөнгө хуваарилахад сум, дүүргийн орон нутгийн хөгжлийн индексийг ашиглах, улмаар уг индексийг Сангийн яам тооцож, нийтэд зарлаж байх асуудлыг аудитын зөвлөмжөөс хасах саналтай байна.

ТӨРИЙН НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА



ХИГАНЦОГТ

Санал өгөх тайлбар:

1. ОНХНС-аас аймаг, нийслэлийн ОНХС-д олгосон орлогын шилжүүлгийн гүйцэтгэл нь батлагдсан дүнгээс 16.7 хувиар буурсан байна гэснийг Сангийн яамны саналын дагуу 16.7 хувиар дутуу байна гэж өөрчиллөө.
2. Засгийн газар төсвийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхдээ Төсвийн тухай хуулийн 22 дугаар үйлийн 22.6.3, 32 дугаар зүйлийн 32.2.6 дахь заалтыг хангасан байх шаардлагатай тул саналыг хүлээж авах боломжгүй.
3. Монгол Улсын Ерөнхийлөгчөөс санаачлан боловсруулж УИХ-д өргөн барьсан Төсвийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл нь хэлэлцэгдэж, батлагдаагүй тул саналыг хүлээн авах боломжгүй байна.

ДҮГНЭЛТ:

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. ОНХС-ийн хөрөнгийг хуваарилахад ашиглах сумын хөгжлийн индексийг Сангийн яам Сумын хөгжлийн индекс тооцох аргачлалын дагуу тооцож зарлаагүй байна.
2. ОНХС-ийн хөрөнгөөр орон нутгийн хөгжлийн бодлоготой уялдаагүй, баг, хорооны ИНХ болон иргэдийн саналаар дэмжигдээгүй, ач холбогдлоор нь эрэмбэлээгүй, ИТХ-аар батлагдаагүй, зураг төсөвгүй, ТЭЗҮ-ийг тооцоолоогүй төсөл, арга хэмжээг төлөвлөж, гүйцэтгэсэн, өмнөх аудитаар өгсөн зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлээгүй байна.
3. ОНХС-ийн хөрөнгийн дийлэнх хэсгийг жил бүр явган хүний зам, гудамжны гэрэлтүүлэг, хогийн цэг байгуулах, шугам сүлжээний засвар гэх мэт төсөл, арга хэмжээнд зарцуулж буй нь сангийн гол зорилтыг хангаж чадахгүйд хүргэж байгаа тул холбогдох хууль, журам, зааврыг шинэчлэн боловсруулах шаардлагатай байна.
4. ОНХС-ийн нийт эх үүсвэрийн 35.8 хувь буюу 47.9 тэрбум төгрөгийг холбогдох хууль, журмыг зөрчиж зарцуулсан, өмнөх онуудад гарч байсан зөрчлийг давтан гаргаж байгаа зэрэг нь төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлсэн албан тушаалтнуудын ажлын хариуцлага сул, удирдлага арга зүй болон хариуцлагын тогтолцоо хангалтгүй байгаатай холбоотой байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан албан тушаалтанд зөвлөж байна. Үүнд:

Монгол Улсын Ерөнхий сайдад:

1. Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийг хууль, журмын дагуу зарцуулаагүй, хяналт тавих үүргээ биелүүлээгүй, өмнөх аудитаар илэрсэн зөрчлийг энэ онд давтан гаргасан, зөвлөмжийг хэрэгжүүлээгүй аймаг, нийслэлийн Засаг дарга нарт хариуцлага тооцох;

Монгол Улсын Сангийн сайдад:

1. ОНХС-ийн хөрөнгийг хуваарилахад ашиглах “Сумын хөгжлийн индекс тооцох аргачлал”-аар сумын хөгжлийн индексийг тооцож, зарлах;
2. Аймаг, нийслэлийн холбогдох албан тушаалтнуудад ОНХС-ийн хөрөнгийн төлөвлөлтийг бодитой, үндэслэл сайтай боловсруулах чадвар эзэмшүүлэх, сургаж дадлагажуулах;
3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын чиг үүрэгт хэт жижиглэсэн хөтөлбөр, төсөл, арга хэмжээг тусгахгүй, урсгал зардлыг санхүүжүүлэхгүй байхаар холбогдох хууль, журам, зааварт өөрчлөлт оруулах.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын дарга, Засаг дарга нарт:

1. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлэх ажлын төлөвлөгөөг батлахдаа холбогдох хууль, журмыг зөрчихгүй байх;
2. ОНХС-ийн хөрөнгөөр төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхдээ холбогдох хууль, журам, зааврыг баримталж, сангийн хөрөнгөөр бий болсон хөрөнгийн ашиглалт, арчлалт, хамгаалалтыг сайжруулах;
3. ОНХС-ийн хөрөнгөөр хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний хэрэгжилтийг хянах хяналтын хороо, дотоод аудитыг ажиллуулах, захиалагчийн хяналтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх, зөрчил гаргасан гүйцэтгэгчдэд хариуцлага тооцох;



МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОРЫН
ТУШААЛ

2016 оны 06 сарын 03 өдөр

Дугаар А/49

Улаанбаатар хот

Аудитын тайланг баталгаажуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4.5 дахь заалт "Гүйцэтгэлийн аудитын тайланг хянан баталгаажуулах журам"-ын 4.2-т заасныг үндэслэн ТУШААХ нь:


1. "Орон нутгийн хөгжлийн сангийн зарцуулалт"-д хийсэн нийцлийн аудитын тайланг баталсугай.

2. Аудитын тайланг Улсын Их Хурлын Төсвийн Байнгын хороо, Сангийн яаманд тус тус хүргүүлсүгэй.

3. Аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, үр дүнг 2016 оны 10 дугаар сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг Монгол Улсын Сангийн сайдад зөвлөсүгэй.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Үндэсний аудитын газрын Нийцлийн аудитын газрын дарга /Б.Алтанзул/, аймаг, нийслэлийн Тэргүүлэх аудитор нарт үүрэг болгосугай.

МОНГОЛ УЛСЫН
ЕРӨНХИЙ АУДИТОР



А.ЗАНГАД

\\10.10.10.20\Bichig_Kherreg\Tushaal\2016\0603NAG1.Docx

000428

Хавсралт №1

ОНХС-ийн хөрөнгөөр 2015 онд хэрэгжүүлсэн төсөл, хөтөлбөр

№	Аймаг, нийслэл, сум, дүүргийн нэр	ИТХ-аар батлагдсан ХО, хөтөлбөр, төсөл арга хэмжээ		Гэрээ байгуулсан ХО, хөтөлбөр, төсөл арга хэмжээ		Бүрэн хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл арга хэмжээ				Дууу хэрэгжсэн ХО, хөтөлбөр, төсөл арга хэмжээ				Огт хэрэгжээгүй ХО, хөтөлбөр, төсөл арга хэмжээ	
		тоо	өртөг сая/төг	тоо	Гэрээний дүн сая/төг	тоо	Гэрээний дүн сая/төг	Үүнээс дууу олгосон санхүүжилт тоо	өртөг сая/төг	тоо	Гэрээний дүн сая/төг	Олгосон санхүүжилт сая/төг			
1	Архангай	214	5,580.0	171	5,106.2	155	4,722.5	45	418.3	16	407.0	328.4	43	651.2	
2	Баян-Өлгий	299	8,731.3	299	8,587.6	282	8,323.1	73	2,177.7	15	251.5	2.0	2	13.0	
3	Баянхонгор	367	6,210.4	330	5,429.2	284	4,015.6	32	265.5	34	1,325.6	1,369.4	49	869.2	
4	Булган	226	5,914.9	198	5,658.4	180	4,771.1	12	388.3	18	887.5	490.2	28	847.3	
5	Говь-Алтай	272	8,086.2	244	6,589.1	222	5,695.2	19	234.1	22	1,019.0	481.6	28	236.2	
6	Говьсүмбэр	82	2,843.2	71	2,570.1	60	2,046.5	13	49.4	11	523.3	142.0	11	273.1	
7	Дархан-Уул	103	17,654.6	95	3,798.7	88	3,012.6	52	461.7	15	1,424.9	452.0	-	-	
8	Дорноговь	89	5,129.1	81	6,356.0	73	5,279.1	16	526.5	8	1,076.9	284.4	8	360.9	
9	Дорнод	184	5,228.8	115	3,203.3	179	5,103.0	12	435.4	-	-	-	5	100.3	
10	Дундговь	210	9,448.9	183	10,507.4	167	5,366.5	5	10.0	11	5,079.2	2,411.9	32	950.0	
11	Завхан	327	5,109.8	226	4,162.9	211	3,674.3	17	101.8	27	471.4	362.8	89	935.2	
12	Орхон	101	5,275.6	65	2,391.5	99	5,168.7	23	317.1	2	106.9	-	-	-	
13	Өвөрхангай	270	5,966.1	245	5,966.1	191	4,804.1	12	116.2	54	1,162.0	825.4	25	269.1	
14	Өмнөговь	191	11,329.0	115	14,738.3	161	14,533.7	14	111.2	4	212.8	169.7	26	1,161.6	
15	Төв	233	5,129.3	210	3,376.4	191	2,231.4	15	166.3	19	1,145.0	566.6	23	1,752.9	
16	Ховд	329	5,400.2	243	4,774.9	215	3,841.4	4	144.9	28	977.5	679.2	86	1,065.0	
17	Хөвсгөл	356	6,862.1	220	4,040.3	293	6,010.6	61	405.6	27	643.1	221.1	36	208.4	
18	Хэнтий	336	5,985.9	298	5,157.4	283	4,707.2	28	239.9	15	173.1	113.7	38	368.3	
19	Сүхбаатар	110	3,484.9	-	-	96	2,898.7	-	-	11	320.4	-	3	265.8	
20	Сэлэнгэ	217	4,610.1	80	2,109.5	164	3,497.2	11	287.5	19	633.1	254.5	34	446.9	
21	Увс	275	7,114.2	222	5,075.4	199	4,632.5	47	487.6	23	442.8	266.7	53	1,939.7	
22	Улаанбаатар	436	24,576.8	414	23,262.3	293	15,337.2	12	58.0	121	7,925.1	-	22	1,314.6	
	Нийт дүн	5,227	165,671.3	4,125	132,861.0	4,086	119,672.2	523	7,402.9	500	26,208.1	9,421.6	641	14,028.6	